

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Б. БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

"ЧУХАМЖАРГАЛАН" ХХК
ЗАХИРАЛ

Г.ГАНТУЛГА / ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ/

“ЧУХАМЖАРГАЛАН”ХХК НИЙ ӨМНӨГОВЬ АЙМАГ, ГУРВАНТЭС СУМ, УРТ
БАГ, ХӨВ НЭРТЭЙ ГАЗАРТ ХЭРЭГЖИНЭ. “БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫГ
ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛА” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: SGMV-00009
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 3614093

ХЯНАСАН:
ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

БАТЧУЛУУН . ДУЛМАА

БОЛОВСРУУЛСАН:
"ЧУХАМЖАРГАЛАН" ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН

Д.БОЛОРТУЯА

2024 ОН

ГАРЧИГ

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1 Төслийн байршил, мэдээлэл	6
1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл:	6
1.3 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал	7
1.3.1. Барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө	7
1.3.2. Усан хангамж	7
1.3.3. Цахилгаан хангамж	10
1.4 Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал	11
1.5 Төслийн үр ашиг	12
1.6 Төслийн техник тоног төхөөрөмж	12
1.7 Ажиллах хүчний тухай мэдээллүүд	13
1.8 Уурхайн технологийн дараалал	13
1.9 Тухайн жилийн уурхайн ашиглалтын төлөвлөгөө	14
2.ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	16
2.1 Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл	16
2.2 Агаарын чанар	17
2.3 Хөрсөн бүрхэвч	17
2.4 Ургамлан нөмрөг	20
2.5 Гадаргын ус	28
2.6 Газар доорхи ус	30
2.7 Амьтны аймаг	31
2.8 Сум орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал	35
3.ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ..	48
3.1. Төслийн болзошгүй нөлөөлөл	48
3.2. Төслийн гол сөрөг нөлөөлөл	54
3.2.1 Цаг агаарын хүчин зүйлсээс төслийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл	54
3.2.2 Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ	54
3.2.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ	55
3.2.4 Усан орчинд үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ	56
3.2.5 Ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл	56
3.2.6 Дуу шуугианы нөлөөлөл	57
4.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	58
5.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	59
5.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	60
5.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	63
5.3 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	63
5.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	64
5.5 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..	64
5.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	65
5.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	66
5.8 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	67
5.9 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	67

5.10 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	70
---	----

ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн байршил.....	6
Зураг 2. Уурхайн гадаад цахилгаан хангамжийн ерөнхий схем, дэд станцын зураг.....	10
Зураг 3. Уурхайн дотоод цахилгаан хангамжийн ерөнхий схем.....	11
Зураг 4. Төсөлд хэрэглэгдэх тоног төхөөрөмж.....	13
Зураг 5. Барилгын чулуу бутлах технологийн схем.....	14
Зураг 6. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөршлийн зураг.....	16
Зураг 7.Төслийн талбайн налуугийн зураг.....	16
Зураг 8.Төслийн талбайн хөрсний хэв шинжийн зураглал.....	17
Зураг 9. Төслийн талбайн хөрсний дээж авч буй байдал.....	20
Зураг 10.Төслийн талбайн ургамалжилтын зураг.....	20
Зураг 11. Төслийн талбайн ерөнхий төлөв.....	23
Зураг 12. Төслийн талбайн доторх ургамал бичиглэл №1.....	24
Зураг 13. Төслийн талбайн доторх ургамал бичиглэл №2.....	25
Зураг 14. Төслийн талбай дахь ургамалжилтын байдал-Шар модот хотир ургасан байдал.....	26
Зураг 15. Судалгааны талбайн ургамалжилтын төлөв байдал.....	26
Зураг 16.Төслийн талбайн бодит зураглал №1.....	27
Зураг 17. Төслийн талбайн бодит зураглал №2.....	27
Зураг 18. Төслийн талбайн бодит зураглал №3.....	28
Зураг 19. Төслийн талбайн бодит зураглал №4.....	28
Зураг 20.Төслийн талбайн сав газрын зураглал.....	29
Зураг 21.Төслийн талбайн орших цэвдгийн бүслүүр.....	30
Зураг 22. Төслийн талбайн ойролцоохи улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн байршил.....	35
Зураг 23. Гурвантэс сумын 2017-2022 оны хүн амын мэдээ харьцуулалт, сум багаар харууллаа.....	36
Зураг 24. Гурвантэс сумын хүн амын өсөлтийн динамик ба хуваарилалт, 2018-2022.....	39
Зураг 25. Гурвантэс сумын малын байршил болон багууд дахь нийт малын тооны өөрчлөлт.....	42
Зураг 26. Гурвантэс сумын цахим орчин дахь мэдээллийн сайт болон facebook –ийн харагдах байдал /2023.11.01/.....	43
Зураг 27. Гурвантэс сум дахь гадаад хэлний сургууль.....	45
Зураг 28. Сумын ЕБС-ын болон цэцэрлэгийн 2019, 1975 оны барилгууд.....	46

ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Барилга, байгууламж, хийц бүтэц.....	7
Хүснэгт 2. Ахуйн ундны усны тооцоо.....	8
Хүснэгт 3. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ.....	9
Хүснэгт 4. Биологийн нөхөн сэргээлтийн ус хэрэглээ.....	9
Хүснэгт 5. Усны нийт хэрэглээний тооцоо.....	9
Хүснэгт 6. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ.....	10

Хүснэгт 7. Дэд станцын техникийн үзүүлэлт	10
Хүснэгт 8. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	12
Хүснэгт 9. Нийт ажилчид	13
Хүснэгт 10. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	15
Хүснэгт 11. Хөрсний морфологи бичиглэл.....	18
Хүснэгт 12. Талбай орчмын ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүн.....	21
Хүснэгт 13. Бичиглэл -1	24
Хүснэгт 14. Бичиглэл -2	25
Хүснэгт 15. Өмнөговь аймгийн шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ.....	29
Хүснэгт 16. Алтайн өвөр говийн тойрогт тохиолдох хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл	32
Хүснэгт 17.Гурвантэс сумын нийт нутгийн хэмжээ, Газрын нэгдсэн сангийн ангиллаар, 2022 он.....	37
Хүснэгт 18. Гурвантэс сумын ХАА-н эдэлбэр газрын ашиглалт, 2022 он	37
Хүснэгт 19. Гурвантэс сумын хүн ам болон өрхийн тоо, тэдгээрийн өөрчлөлт. 2017-2022	39
Хүснэгт 20. Гурвантэс сумын ажил хайгчдын хөдөлгөөн, жишээ болгосон 2022 оны 10 сараар	40
Хүснэгт 21. Гурвантэс сумын малчин өрх, нийт өрхөд эзлэх хувийн жин, 2018-2022 он ...	40
Хүснэгт 22. Гурвантэс сумын малын боо, нийт толгой болон төрлөөр, 2016-2022 он	42
Хүснэгт 23. Сумын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гол онцлогууд, 2022 он.....	44
Хүснэгт 24. Гурвантэс сумын соёл, боловсролын байгууламжууд	46
Хүснэгт 25. Төслийн үйл ажиллагааны уед байгаль орчинд үзүүлэх бохирдол, нөлөөллийн эх үүсвэр, шинж чанар, өртөгдлийн байдал.....	49
Хүснэгт 26. Болзошгүй нөлөөллийн магадлан жагсаалт	50
Хүснэгт 27. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт	53
Хүснэгт 28. Агаарын чанарт үзүүлэх сорог нолооллийн үнэлгээ.....	55
Хүснэгт 29. Хөрсөнд үзүүлэг сөрөг нөлөөллийн үнэлгээ.....	55
Хүснэгт 30. Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ.....	56
Хүснэгт 31. Ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөө	57
Хүснэгт 32. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	60
Хүснэгт 33. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдэх ажил	63
Хүснэгт 34. осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	65
Хүснэгт 35. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	66
Хүснэгт 36. БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	67

1. 1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Бага-Овоо багийн нутагт орших SGMV-00009 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 103.9 га талбайд хэрэгжинэ. Төсөл хэрэгжүүлэгч нь 1111003044 улсын бүртгэлийн дугаартай, 3614093 регистрийн дугаар бүхий Чухамжаргалан ХХК юм.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2015 оны 11 сарын 26-ны өдрийн тушаалаар тус аймгийн Гурвантэс сумын Урт багийн нутагт орших “Хөв” нэртэй, 00024X дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг “Чухамжаргалан” ХХК-нд олгосон байдаг. Ордын нөөцийг тогтоох зорилгоор эрэл, хайгуулын ажлыг “Хөв” талбайн хойд хэсэгт 2017 оны 8 дугаар сарын 15-наас эхлэн 2017 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэжээ.

Ордын геологийн нөөцийг бодитой В зэргийн 442,770.0 м³ буюу 1,151,202.0 тн, боломжтой С зэргийн 145,000.5 м³ буюу 377,001.3 тн, нийт бодитой болон боломжтой (В+С) зэргийн 587,770.5 м³ буюу 1,528,203.3 тн-р тогтоон улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. (ЭБМЗ-ийн дүгнэлт, дугаар Т/23-10-04).

Энэхүү батлагдсан нөөцөд үндэслэн Өмнөговь аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/1537 дугаар захирамжаар тус аймгийн Гурвантэс сумын Урт багийн Хөв нэртэй газар орших 103.9 гектар талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын SGMV-00009 тоот тусгай зөвшөөрлийг Чухамжаргалан ХХК-д олгосон.


Батлагдсан нөөц, тусгай зөвшөөрлийн мэдээлэл, Чухамжаргалан ХХК-ийн Техникийн даалгаварт үндэслэн, техник-эдийн засгийн үндэслэлийг “Гоулдмэн Прожект” ХХК боловсруулж, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн 2023 оны 07 сарын 05-ны өдрийн Т/23-10-04 тоот дүгнэлтүүдийг үндэслэн АМГТГ-ын даргын 2023 оны 09 сарын 20-ны өдрийн Т/97 тоот тушаалаар ТЭЗҮ-г батлуулан ажилласан.

Түгээмэл тархацтай ашигт малтал Хөв нэртэй ордод “Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл” 5 жилийн хугацаатай хэрэгжих бөгөөд жилд 140.0 мян.м³ дайрга олборлох хүчин чадалтай болно. Ил уурхай нь жилд 350 хоног, хоногт 2 ээлж, ээлжинд 12 цагаар ажиллана. Энэхүү төсөлд 76 хүн ажиллахаар төлөвлөсөн болно.

Уурхайн ашиглалтын хугацаанд ил уурхайгаас 168.3 мян.м³ хөрс хуулж, 504.1 мян.м³ барилгын чулуу олборлоно. Хөрс хуулалтын коэффициент (К_{хх})=0.33 м³/тн байна. Хөрс хуулалт, олборлолтонд ажиллах экскаваторыг 1.1 м³ утгуурын багтаамжтай экскаватор гүйцэтгэх бөгөөд 15 тн-ийн даацтай Номю загварын автосамосвал тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэнэ. Мөн 3м³ багтаамжтай ачигч анхдагч дайргыг бутлуурт хийж түүнээс төслийн эцсийн бүтээгдэхүүн гарах бөгөөд ашиглалтын 5 жилийн хугацаанд 506.7 мян.м³ дайрга үйлдвэрлэнэ. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчны мэргэжлийн байгууллага болох Төгрөг Баян Хангай ХХК боловсруулж, БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн дэд зөвлөлөөр 2024 оны 06 дугаар сарын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан болно.

1.1 Төслийн байршил, мэдээлэл

Тухайн төслийн талбай нь Засаг захиргааны нэгжийн хуваариар Өмнөговь аймгийн Гурвантэс суманд харъяалагдах ба сумын төвөөс урагш 40 км, Шивээхүрэнгийн боомтоос 45 км-т оршино. Мөн тусгай зөвшөөрлийн талбай нь “Монголын алт (МАК)” ХХК-ийн Нарийн сухайт, “Саусгоби Сэндс” ХХК-ийн Овоот Толгой, “Өсөх Зоос” ХХК-ийн “Хүрэн Шанд” нүүрсний уурхайн ашиглалтын талбайгаас хойд зүгт 2 км зайд байрлана.



Зураг 1. Төслийн байршил

1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл:

Төслийн нэр	Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар
Төсөл хэрэгжүүлэгч	“Чухамжаргалан” ХХК
Бүртгэлийн дугаар	1111003044
Регистрийн дугаар	3614093
Ашигт малтмал ашиглалтын тусгай	SGMY-00009
Талбайн хэмжээ	103.9 га
Төслийн зорилго, ач холбогдол	“Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл нь Монгол улсын стандартад нийцсэн дайрга үйлдвэрлэх улмаар Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд эдийн засгийн үр ашигтайгаар, иж бүрэн ашиглах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, байгаль орчинд сөрөг нөлөө багатай үйл ажиллагаа явуулж нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байрууд бий болгож нийгэм-эдийн засгийн үр өгөөжийг

	өндөр байлгахад төслийн үндсэн зорилго оршино.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	“Өмнөговь аймаг, Гурвантэс сум, Бага-Овоо
Төслийн байршил	Өмнөговь аймаг, Гурвантэс сум, Бага-Овоо баг, Хөв
Чухамжаргалан ХХК захирал	А.Тэмүүлин

1.3 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал
Барилгын чулууны ордын уурхай, үйлдвэрийн барилга байгууламж, ашиглалтын үеийн үйл ажиллагаанд шаардагдах ус, эрчим хүчний хангамж, засвар үйлчилгээ зэрэг дэд бүтцийн шийдлийг энэ бүлэгт тусгалаа.

1.3.1. Барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө

Уурхай, үйлдвэрийн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтах бөгөөд эдгээр нь уурхайн баруун урд талд байрлана.

Хүснэгт 1. Барилга, байгууламж, хийц бүтэц

№	Нэр	Хийц, бүрдэл	Тоо, ш
1	Оффис, ажилчдын байр	Зөөврийн байгууламж	3
2	Засварын газар, материалын агуулах	Чингэлэг	1
3	Түлшний агуулах сав	Иж бүрэн	1
	Дүн		5

Машин техник, тоног төхөөрмжийн завсар үйлчилгээ

Ил уурхайд жижиг засварын газрыг барьж байгуулна. Уурхайн машин техник, үйлдвэрийн тоног төхөөрмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт дугуй засвар, гагнуур, компрессор зэргийг суурилуулна.

Шатах тослох материалын агуулах

Түлш хадгалах зориулалтаар 5-10 тонны багтаамжтай ган сав 1 ширхэгийг, дизелийн масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь тус тус хадгална. ШТМ-ын гал аюулгүй байдлын шаардлага, норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

1.3.2. Усан хангамж

Унд ахуйн усан хангамж

Уг төслийн талбай нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5-р багт байрлах бөгөөд уурхайн ажилчдын унд ахуйн хэрэглээ, ил уурхайн зам усалгаа болон ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд шаардлагатай усны хэрэглээг гүний худгаас хангаж байна.

Усны эх үүсвэр, байршил:

Технологи ажилчдын унд ахуй, зам талбайн тоосжилт дарах ус хэрэглээг Бласт ХХК-тай гэрээ байгуулсаны үндсэн дээр зөөврөөр ус хангадаг.

Худаг №1: Ундарга: 1л/с буюу 86.4м³/хон

Байршил: 101° 13' 07,33^{II}, 43° 14' 16.70^{II}

Худаг №2: Ундарга: 3л/с буюу 259.2м³/хон

Байршил: 101° 13' 32^{II}, 43° 1' 47^{II}

Тухайн усаар хангагч Бласт ХХК-ийн Гурвантэс сумын нутагт үйл ажиллагаа явуулж Тэсрэх бодисны үйлдвэр төслийн 2023 оны 01 сарын 18-ны өдрийн №06 тоот усны боломжит нөөцийн дүгнэлтээр нийт ашиглах усны хэмжээ хоногт 115.8м³/хон, 13605.6м³/жил гарсан байна. /Хавсралтаар оруулав/

Нийт 2 худгийн усны боломжит ундарга: 345.6м³/хон

Ус түрээслэгч буюу “Чухамжаргалан” ХХК-ийн төслийн нийт ашиглах усны хэмжээ хамгийн өндөр хэрэглээтэй 3 болон 4-р жилээр тооцоход хоногт 186.08м³/хон буюу 6088м³/жил гарсан нь тус 2 худаг эдгээр 2 төслийн хувьд хангалттай хүрч байна. /Хүснэгт 5. Нийт усны тооцоо/-г харж болно.

Ахуйн усны тооцоо:

Төслийн баг байнгын 76 ажилчинтай байна. Монгол улсын хөдөлмөрийн хуулиар заасан ажил амралтын цагийг зохицуулах үүднээс үйлдвэрийн ажилчид сард 21 хоног ажиллах ба 1 ээлжийн ажилчид байна. Ундны усанд байнга шинжилгээ хийж, хяналт тавьж байх шаардлагатай. Ялангуяа ундны усны нөөцийн савнаас эрүүл ахуйн байнга шинжилгээ авах, ундны усанд улирал болгон бактериологи болон хүнд металлын шинжилгээ, ерөнхий химийн шинжилгээ хийлгэх шаардлагатай.

“Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 14 дүгээр хавсралт “Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын усны норм”-д зааснаар албан байгууллагад 1 ажилтны хоногийн дундаж усны хэрэглээ нь 80 л болно.

Хүснэгт 2. Ахуйн ундны усны тооцоо

№	Үзүүлэлтүүд	Норм, л/хоног	Хүний тоо,	Усны зарцуулалт		
				Хоногт хэрэглэх ус м ³ /хоног	Жилд ажиллах хоног	м ³ /жил
1	Ахуйн усны хэрэглээ	80	76	6.08	350	2128
Нийт			76		350	2128

Жилд нийт ахуйн усны хэрэгцээнд жилд 2128 м³ ус ашигладаг. Төсөл хэрэгжих нийт 4 жилийн хугацаанд 8512м³ ус ашиглана.

3) Зам талбайн усны хэрэглээ

БОАЖНХЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар баталсан ус хэрэглээний нормын 13-р хавсралтын дагуу 1 м² гудамж, зам талбайг 2.0 л усаар усална гэсэн нормоор усны хэрэгцээг тодорхойлбол. Уурхайн дотоод тээврийн зам 4500 м², хоногт 2 удаа услах ба жилд цэвэр ажиллах 350 хоног буюу 1 жилд 100 хоног усална гэж тооцлоо.

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4-10 сард буюу дулааны улиралд явуулна. 11-3-р сард буюу

өвлийн улирал замыг хусаж цэвэрлэнэ. Усны машин нь тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замыг хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Хэрэв цаг агаар, хөдөлгөөний эрчмийн байдлаас шалтгаалан тоосжилт ихэвсэл замын тоос дарах ажиллагааг дахин давтана.¹ Эхний жилийн усалгааны замын урт 450м, өргөн 10м нийт услах талбайн хэмжээ 4500 м² байна.

1-р жилд хоногт хэрэглэх усны тооцоо:

➤ $4500 \text{ м}^2 \cdot 2.0 \text{ л/хон} \cdot 2 \text{ удаа} = 18 \text{ м}^3/\text{хоног}$

1-р жилд жилд хэрэглэх усны тооцоо:

➤ $18 \text{ м}^3 \cdot 100 \text{ удаа усална} = 1,800 \text{ м}^3/\text{жил}$

Хүснэгт 3. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ

Ашиглалтын жил	Жилд услах зам, м ²	1 м ² замын усалгаанд шаардагдах ус, литр	Хоногт услах тоо	м ³ /хоног	м ³ /жил 100 хоног усална
1-р жил	4500.0	2.0	2	18.0	1800.0
2-р жил	5000.0	2.0	2	20.0	2000.0
3-р жил	5500.0	2.0	2	22.0	2200.0
4-р жил	6000.0	2.0	2	24.0	2400.0
Нийт ашиглалтын 4 жилийн хугацаанд					8400.0

4) Биологийн нөхөн сэргээлтийн усны хэрэглээ

Төслийн ашиглалтын 4 жилийн хугацаанд нийт 7.8 га уурхайн ухаш талбай нөлөөлөлд өртөх ба техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг уурхайн ашиглалтын 3-4 дэх жилд хийгдэх юм. Уурхайн нийт эюдрэлд өртсөн 7.8 га талбайд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.

Нөхөн сэргээлтэнд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 11-р хавсралтын дагуу 2 настай навчит модыг 40 л/мод нормоор, олон наст ургамлаар нөхөн сэргээсэн талбайг 4 л/м² нормоор услахаар тооцлоо. Усалгааг 14 хоногт 1 удаа хийнэ.

БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-301 дугаар тушаалаар батлагдсан нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу тарилт, суулгалт хийсний дараа нөхөн сэргээлтэд тарьсан ургамлыг бие даан ургах чадвартай болтол нь усалж арчилна гэж заасан байдаг. Усалгааг газрын гадаргын налуу, хэлбэржилт, байрлал, цаг уурын нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хийх ба ялангуяа нөхөн сэргээлтийн эхний жилд хөрсний чийгийн горимыг барихын тулд хийх усалгааны тоо 14 хоногт 1 удаа, сард 2 удаа, жилд 10 удаа байна.

Хүснэгт 4. Биологийн нөхөн сэргээлтийн ус хэрэглээ

Шимт хөрсөөр хучилт эхлэх үеэс тоолсон хугацаа	Жилд нөхөн сэргээлт хийх талбай, м ²	Хоногт усалгаанд шаардагдах ус, м ³	Жилд хэдэн удаа услах	жилд, м ³
3-р жил	39000 мкв зүлэг ногоо	156.0	10	1560.0
4-р жил	39000 мкв зүлэг ногоо	156.0	10	1560.0
Нийт		-	-	3120.0

5) Нийт усны хэрэглээ

Хүснэгт 5. Усны нийт хэрэглээний тооцоо

№	Үзүүлэлт	2024 он	2025 он	2026 он	2027 он
м.куб/жил					
1	Зам талбайн усалгаа	1800	2000	2200	2400


¹ ТЭЗҮ 48-49-р хуудас

2	Унд, ахуйн усны хэрэглээ	2128	2128	2128	2128
3	Биологийн нөхөн сэргээлт	-	-	1560	1560
Нийт		3928	4128	58888	6088

4 Жилд нийт хэрэглэх усны хэмжээ: 20,032 м³/жил. Үүнээс гэрээтээр худгаас зөөврийн усаар хангах ба тус бүр 3л/сек буюу 259,2м³/хон учраас усны ундарга хангалттай гэж үзлээ. Худгаас нийт 20,032 м³/4жил хэрэглэнэ.

1.3.3. Цахилгаан хангамж

Хөвийн барилгын чулууны орд нь өмнөд бүсийн цахилгаан дамжуулах шугамаас 4 км зайд байрлах ба хамгийн ойр байрлах “Нарийн Сухайт Эрчим” ХХК-ийн дэд станцаас уурхайн талбай хүртэл 6 кВ-ын ЦДАШ-аар төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Мөн уурхайд 6/0.4кВ-ын дэд станц байгуулан уурхайн цахилгаан хэрэглэгчдийг эрчим хүчээр хангаж байна.




Зураг 2. Уурхайн гадаад цахилгаан хангамжийн ерөнхий схем, дэд станцын зураг

Хүснэгт 6. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ

№	Хэрэглэгчийн нэр	Суурилагдсан чадал, кВт	Ажиллах хоног	ЦЭХ-ний зарцуулалт, мян.кВт*цаг	
				Хоногт	Жилд
1	Засварын цех	24.9	350	0.36	125.49
2	Уурхайн хотхон	75.0	350	1.62	567.11
3	Бутлуурын цех	119.9	350	2.95	906.61
4	Уурхайн бусад нэгж, хэсэг	21.8	350	0.37	128.29
Нийт		229.9	350	4.9	1721.5

Хүснэгт 7. Дэд станцын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжээ
1	Номиналь хүчдэл, кВ өндөр/нам	6/0.4кВ
2	Ороомгийн холболтын схем ба бүлэг	Ү/Үн-0, Д/Үн-11
3	Ачаалалгүй үеийн алдагдал, Вт	750
4	Богино залгааны алдагдал, кВт	560
5	Ачаалалгүй гүйдэл, %	1.0

6	Богино залгааны хүчдэл, %	4.5	
---	---------------------------	-----	---


Уурхайн үйл ажиллагаа жилийн 350 хоногт явагдах ба уурхайн дотоод цахилгаан хангамжийн хамрах хүрээг дараах байдлаар ангилна. Үүнд:

Уурхайн хэсэг:

- Уурхайн үйлдвэрийн барилга байгууламжууд, бутлан ангилах цех, засварын газар, шатахуун түгээх станц, сэлбэг материал агуулах
- Уурхайн ерөнхий гэрэлтүүлэг болон гэрэлтүүлэг

Үйлдвэрлэлийн туслах байгууламжууд ба ахуйн цахилгаан хангамж:

- Захиргааны байр
- Ажилчдын сууц
- Хотхоны гэрэлтүүлэг
- Цайны газар
- Худаг гэх мэт



Зураг 3. Уурхайн дотоод цахилгаан хангамжийн ерөнхий схем

1.4 Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал

Ордын геологийн нөөцийг бодитой В зэргийн 442,770.0 м3 буюу 1,151,202.0 тн, боломжтой С зэргийн 145,000.5 м3 буюу 377,001.3 тн, нийт бодитой болон боломжтой (В+С) зэргийн 587,770.5 м3 буюу 1,528,203.3 тн-р тогтоон улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. (ЭБМЗ-ийн дүгнэлт, дугаар Т/23-10-04).

Энэхүү батлагдсан нөөцөд үндэслэн Өмнөговь аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/1537 дугаар захирамжаар тус аймгийн Гурвантэс сумын Урт багийн Хөв нэртэй газар орших 103.9 гектар талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын SGMV-00009 тоот тусгай зөвшөөрлийг Чухамжаргалан ХХК-д олгосон.

Батлагдсан нөөц, тусгай зөвшөөрлийн мэдээлэл, Чухамжаргалан ХХК-ийн

Техникийн даалгаварт үндэслэн, техник-эдийн засгийн үндэслэлийг “Гоулдмэн Прожект” ХХК боловсруулж, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн 2023 оны 07 сарын 05-ны өдрийн Т/23-10-04 тоот дүгнэлтүүдийг үндэслэн АМГТГ-ын даргын 2023 оны 09 сарын 20-ны өдрийн Т/97 тоот тушаалаар ТЭЗҮ-г батлуулан ажилласан.

Түгээмэл тархацтай ашигт малтал Хөв нэртэй ордод “Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл” 5 жилийн хугацаатай хэрэгжих бөгөөд жилд 140.0 мян.мЗ дайрга олборлох хүчин чадалтай болно. Ил уурхай нь жилд 350 хоног, хоногт 2 ээлж, ээлжинд 12 цагаар ажиллана. Энэхүү төсөлд 76 хүн ажиллахаар төлөвлөсөн болно.

Уурхайн ашиглалтын хугацаанд ил уурхайгаас 168.3 мян.мЗ хөрс хуулж, 504.1 мян.мЗ барилгын чулуу олборлоно. Хөрс хуулалтын коэффициент (Кхх)=0.33 мЗ/тн байна. Хөрс хуулалт, олборлолтонд ажиллах экскаваторыг 1.1 мЗ утгуурын багтаамжтай экскаватор гүйцэтгэх бөгөөд 15 тн-ийн даацтай Номю загварын автосамосвал тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэнэ. Мөн 3м³ багтаамжтай ачигч анхдагч дайргыг бутлуурт хийж түүнээс төслийн эцсийн бүтээгдэхүүн гарах бөгөөд ашиглалтын 5 жилийн хугацаанд 506.7 мян.мЗ дайрга үйлдвэрлэнэ.

1.5 Төслийн үр ашиг

Ашиглалтын 4 жилийн хугацаанд нийт 505.6 мян.м³ дайрга борлуулж 25.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 21.7 тэрбум төгрөгийн зардал гаргахаар байна. Мөн нийт хуримтлагдсан мөнгөн урсгал 2.03 тэрбум төгрөг, дискаунтын түвшинг жил бүр 10%-р тооцоход дискаунтлагдсан мөнгөн урсгал буюу ирээдүйн мөнгөний одоогийн үнэ цэнэ NPV=1.12 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын өгөөжийн дотоод норм 34%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 2.05 жил болж байна.

- Улс орон нутгийн төсөвт нийтдээ 10 төрлийн татвар төлбөр төлж байна. Уурхайн ашиглалтын нийт хугацаанд улс орон нутгийн төсөвт 5.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр байна.

Хүснэгт 8. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

6	Эдийн засаг		
6.1	Бүтээгдэхүүн борлуулах үнэ /10÷40 мм/	төг/м ³	50,000.0
6.2	Бүтээгдэхүүн борлуулах үнэ /5÷10 мм/	төг/м ³	34,000.0
6.3	Борлуулалтын орлого	сая.төг	25,265.8
6.4	Нийт зардал	сая.төг	21,736.0
6.5	Татварын дараах орлого	сая.төг	3,176.7
6.6	1 м ³ дайрганы бүрэн өөрийн өртөг	төг/м ³	42,987.3
6.7	Хөрөнгө оруулалт	сая төг	2,149.0
6.8	Өнөөгийн үнэ, цэнэ NPV=10%	сая.төг	1,124.6
6.9	Өгөөжийн дотоод норм, IRR	%	34%
6.10	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	жил	2.05
6.11	Улс, орон нутагт оруулах татвар, төлбөр	сая.төг	5,201.4

1.6 Төслийн техник тоног төхөөрөмж

Төслийн үйл ажиллагаанд 1 экскаватор, 4 автосамосвал, 1 дугуйт утгуурт ачигч, бутлуур, суудлын машин, 1 усны машин зэрэг хөдөлгөөнт болон суурин тоног төхөөрөмж ажиллана.

Барилгын чулууны ордын жилийн хүчин чадал бага ба үүнтэй уялдан уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийг бага болон дунд хүчин чадалтай байхаар сонгосон. Ил уурхайн

хөрс болон хүдрийг өрөмдлөг тэсэлгээний аргаар сийрэгжүүлж, хөрс хуулалт болон хүдэр олборлолтонд CAT 336 маркийн экскаватор, хөрс, хүдэр тээвэрт 15м³ тэвшний багтаамжтай, 20 тн даацтай HOWO маркийн автосамосвалуудыг тус тус ашиглана.



Зураг 4. Төсөлд хэрэглэгдэх тоног төхөөрөмж

1.7 Ажиллах хүчний тухай мэдээллүүд

Энэхүү төсөл 76 хүний ажлын байраар хангана. Мөн энэхүү төсөл жилд 350 хоног, хоногт 2 ээлж, ээлжинд 12 цагаар ажиллана.

Хүснэгт 9. Нийт ажилчид

Хэлтэс	Ажилтан	Сарын цалин, мян.төг	Нийт ажилчид
Төв оффисын ажилчид	Гүйцэтгэх захирал	4,500	1
	Хүний нөөцийн менежер	1,800	1
	Нягтлан бодогч	1,800	1
	Хангамжийн менежер	1,500	1
	Захирлын жолооч	1,200	1
Нийт		10,800	5

1.8 Уурхайн технологийн дараалал

Уурхайн олборлолт

Ил уурхайн эцсийн хүрээнд 168.3 мян.м3 хөрс, 506.6 мян.м3 барилгын чулууны нөөц багтах бөгөөд, хөрс хуулалтын дундаж коэффициент 0.13 м3/тн байна. Уурхайн жилийн хүчин чадал 140 мян.м3 барилгын чулуу олборлох бөгөөд уурхайн хүрэн дэх нийт нөөцийг дээрх хүчин чадлаар 4 жил ашиглахаар байна. Уурхайн хүчин чадлыг

Ил уурхайн хөрс хуулалт, барилгын чулуу олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ - ухаж ачих ажиллагаа - автотээвэр - гадаад овоолго гэсэн дарааллаар гүйцэтгэнэ.

Шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2 метрээс ихгүй зузаантайгаар сийрэгжилтийн ажлыг хийлгүйгээр экскаватораар ухаж уурхайн хүрэнээс 15-20 метрийн зайнд байршуулна.

Хөрс хуулалтын ажил: Хөрсийг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлсний дараа ухан ачиж, хөрсний гадаад овоолгод шилжүүлнэ. Хөрсний догол нь


5 метрий өндөртэй. Ил уурхайн хөрс хуулалтанд 1.1 м³-ийн шанаганы багтаамжтай Hyundai ROBEX-2800 экскаватор, 15 тн даацтай HOWO маркийн автосамосвалын хослол ажиллана.

Бутлуур

Хөв барилгын чулуу боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд нь үйлдвэрийн талбайд бэлэн байгаа захиалагчийн техникийн даалгаварт өгөгдсөн хүчин чадлыг үндэслэн тоног төхөөрөмжийн хүчин чадлын тооцоолол, бүтээгдэхүүн гаргалтын хэмжээ зэргийг тооцов.

Барилгын чулуу бутлах технологи нь дараах үндсэн процессуудад хуваагдана. Үүнд:

- Бутлуур
- Шигших дамжлага
- Бүтээгдэхүүний овоолго
- Бэлэн бүтээгдэхүүний чанарын хяналт.



Зураг 5. Барилгын чулуу бутлах технологийн схем

1.9 Тухайн жилийн уурхайн ашиглалтын төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын хугацаанд ил уурхайгаас 168.3 мян.м³ хөрс хуулж, 504.1 мян.м³ барилгын чулуу олборлоно. Хөрс хуулалтын коэффициент (K_{хх})=0.13 м³/тн байна.

Хөрс хуулалтын ажил нь нөөцийг бүрэн олборлохын тулд уурхай хүрээ тэлэлтээс үүдэн нөөцийн блокийн эргэн тойронд явагдахаар байна. Хөрсний чулуулгийн шинж чанар нь барилгын чулуутай ижил үзүүлэлтэй байгаа тул ашиглалтын явцад нөөцийг нэмэгдүүлэх боломжтой байна.


Хүснэгт 10. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын жил				Нийт
		1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	
Дайрга олборлолт	м ³	139,288	139,288	139,288	86,211	504,075
	тн	362,149	362,149	362,149	224,148	1,310,594
Хөрс хуулалт	м ³	69,938	57,376	28,062	12,938	168,313
Хөрс хуулалтын коэффициент	м ³ /тн	0.19	0.16	0.08	0.06	0.13
Нийт уулын цул	м³	209,226	196,664	167,350	99,148	672,387
Үйлдвэрлэлийн нөөц						
Хаягдлын хувь	%	1.06	1.06	1.06	1.06	1.06
Хаягдлын хэмжээ	м ³	1,494	1,494	1,494	925	5,407
Бохирдлын хувь	%	1.58	1.58	1.58	1.58	1.58
Бохирдлын хэмжээ	м ³	2,206	2,206	2,206	1,366	7,985
Үйлдвэрлэлийн нөөц	м ³	140,000	140,000	140,000	86,652	506,652
	тн	364,000	364,000	364,000	225,294	1,317,295


2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна. Харин төслийн үйл ажиллагааны үр дүнд газар нутгийн эмзэг байдлаас шалтгаалж сөрөг нөлөө үүсэх, үүссэн сөрөг нөлөө хуримтлагдаж болзошгүй нөхцлүүд байх боломжтой байна.



Зураг 6. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөршлийн зураг



Зураг 7. Төслийн талбайн налуугийн зураг

2.2 Агаарын чанар

Гурвантэс сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлтийг Монгол улсын “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн” Дэлхийн цаг уурын байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу Гурвантэс цаг уурын харуулын (ДТД-1476 м) 1991-2020 оны агаарын температур, хур тунадасны стандарт нормыг цаг хугацааны сарын алхамтай тооцоолсон мэдээг ашиглан боловсрууллаа.


Гурвантэс сумын нутагт 2012-2021 оны хооронд дунджаар температур $+3.4...+7.1^{\circ}\text{C}$ -ын хооронд хэлбэлзсэн бөгөөд өвлийн улиралд $-14.3...-10.4^{\circ}\text{C}$, хаврын улиралд $-0.6...+14.7^{\circ}\text{C}$, зуны улиралд $+20.2...+22.9^{\circ}\text{C}$ харин намрын улиралд $-5.2...+14.2^{\circ}\text{C}$ хүрсэн байна. Тухайн бүс нутагт жилд орох хур тунадасны нийлбэр 71.0...200.8 мм-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд өвлийн улиралд 0.2...2.7 мм, хаврын улиралд 1.6...6.5 мм, зуны улиралд 22.5...41.7 мм, намрын улиралд 1.9...16.1 мм-ийн хооронд хэлбэлздэг. Хамгийн их хур тунадас 7 сард дунджаар 41.7 мм, хамгийн бага хур тунадас 1 сард дунджаар 0.8 мм орчим ордог байна.

Судалгаанд хамрагдаж буй нутагт салхины хурд жилд дунджаар 4.2 м/с байсан бөгөөд хавар, намрын улиралд өсж өвөл, зуны улиралд буурсан байна. Салхины хурдны хамгийн их утга нь 5 сард дунджаар 7.1 м/с, хамгийн бага утга нь 2 сард 2.1 м/с ажиглагдсан. Салхины зүг чиглэлийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй.

Гурвантэс сумын салхины зүгийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй жилд дунджаар баруун хойд зүгийн салхи 15-31%, баруун зүгийн салхи 9-24%-ийн давтагдалтай зонхилох боловч зүүн өмнөд зүгийн салхи 5-12% байгаа нь зэргэлдээх зовхисоосоо хавьгүй их давтагдалтай байна.

2.3 Хөрсөн бүрхэвч

Судалгааны талбай нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5-р багийн нутагт байрлах бөгөөд Хөрс-Газарзүйн мужлалаар Говийн их мужийн Говь Алтайн мужийн, Алтайн өвөр 53-р тойрогт хамаарагдана. (Монгол улсын үндэсний атлас 2022).



Зураг 8. Төслийн талбайн хөрсний хэв шинжийн зураглал

Судалгааны талбайд уулын хөрс тархсан байна.


Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь дуд шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж маш бага, шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ бага, хялбар уусах давсны агууламж бага буюу давсжилтгүй, солилцох сууриас Са дунд, Mg Зүсэлт-1 болон Зүсэлт-4 дээр их, Зүсэлт-2 болон Зүсэлт-3 дээр маш их агууламжтай мөн хөдөлгөөнт фосфор, калийн агууламж маш бага байна. Хөрсний үржил шимийн түвшин дундаж байна.

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход Зүсэлт-1, Зүсэлт-3, Зүсэлт-4 нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, Зүсэлт-2 нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний дээжинд хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг (MNS 5850: 2019) Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас доогуур буюу хөрс бохирдолгүй байна.

Хээрийн судалгааны үед талбайн газар ашиглалт, хөрсний гадаргын төлөв байдал, гадаргын болон хөрсний үе давхаргуудын морфологи шинж чанар, хөрсөнд нөлөөлж буй хүчин зүйлс зэргийг тодруулж улмаар хөрсний хими, физик шинж чанарын төлөв байдлыг тодруулах зорилгоор нийт 4 цэгт судалгаа хийж, хөрсний агрохими болон хүнд металлын шинжилгээнд зориулж 4 дээж аван “Нарт шуун консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулж, задлан шинжилгээ хийлгэж дүнг хавсаргалаа.

Хүснэгт 11. Хөрсний морфологи бичиглэл

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Зүсэлт-1	
Байршил	Өмнөговь аймаг Гурвантэс сум	
Координат	43°03'40.88"N	
	101°18'32.50"E	
Өндөр	д.т.д 1611 метр	
Газрын гадарга	0-16°	
Ургамлын бүрхэвч	0%	
Хөрсний нэр	Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс	
Хөрсний фото	Гүн	Морфологи шинж чанар
	0 -20	Цайвар хүрэн өнгөтэй, хуурай, сийрэг, ургамлын үндэс эзлэхүүний 0%, үйрмэг чулуу эзлэхүүний 50%, шилжилт өнгө бага байна. Халтар холимог, цайвар улаандуу бор өнгийн, сийрэг тогтоцтой, улаан өнгийн хэсэг хэсэг шавранцар, толботой, жижиг бөөмөрхөг бүтэцтэй, толбогүй хэсгээрээ элсэнцэр, жижиг сайр чулуу-45%
	20 см	

Хөрсний морфологи бичиглэл	
Хөрсний зүсэлтийн дугаар	Зүсэлт-2
Байршил	Өмнөговь аймаг Гурвантэс сум
Координат	43°03'32.33"N
	101°18'47.58"E
Өндөр	д.т.д 1615 метр
Газрын гадарга	0-16°
Ургамлын бүрхэвч	0%


Хөрсний нэр		Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс
Хөрсний фото	Гүн	Морфологи шинж чанар
	A. 0 -20 20 см	Цайвар бор өнгөтэй, хуурай, сийрэг, ургамлын үндэс эзлэхүүний 0%, үйрмэг чулуу эзлэхүүний 60%, шилжилт өнгө бага байна. Халтар холимог, цайвар улаандуу бор өнгийн, сийрэг тогтоцтой, улаан өнгийн хэсэг хэсэг шавранцар, толботой, жижиг бөөмөрхөг бүтэцтэй, толбогүй хэсгээрээ элсэнцэр, жижиг сайр чулуу-55%
Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар		Зүсэлт-3
Байршил		Өмнөговь аймаг Гурвантэс сум
Координат		43°03'25.44"N 101°18'34.38"E
Өндөр		д.т.д 1613 метр
Газрын гадарга		0-16°
Ургамлын бүрхэвч		0%
Хөрсний нэр		Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс
Хөрсний фото	Гүн	Морфологи шинж чанар
	A. 0 -20 20 см	Цайвар саарал өнгөтэй, хуурай, сийрэг, ургамлын үндэс эзлэхүүний 0%, үйрмэг чулуу эзлэхүүний 90%, шилжилт өнгө бага байна. Цагаан саарал өнгийн, сийрэг тогтоцтой, жижиг бөөмөрхөг бүтэцтэй, толбогүй хэсгээрээ элсэнцэр, жижиг сайр чулуу-95%
Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар		Зүсэлт-4
Байршил		Өмнөговь аймаг Гурвантэс сум
Координат		43°03'10.28"N 101°18'47.74"E
Өндөр		д.т.д 1601 метр
Газрын гадарга		0-16°
Ургамлын бүрхэвч		0%
Хөрсний нэр		Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс
Хөрсний фото	Гүн	Морфологи шинж чанар
	A. 0 -20 20 см	Цайвар саарал өнгөтэй, хуурай, сийрэг, ургамлын үндэс эзлэхүүний 0%, үйрмэг чулуу эзлэхүүний 60%, шилжилт өнгө бага байна. Цагаан саарал өнгийн, сийрэг тогтоцтой, жижиг бөөмөрхөг бүтэцтэй, толбогүй хэсгээрээ элсэнцэр, жижиг сайр чулуу-75%



Зураг 9. Төслийн талбайн хөрсний дээж авч буй байдал

2.4 Ургамлан нөмрөг

“Чухамжаргалан” ХХК-ийн барилгын чулууны орд ашиглах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Төв Азийн мужийн хуурай хэв шинжийн Тост-Нэмэгтийн 60-р тойрогт хамаарагдана.(Монгол Улсын үндэсний атлас, 2022).



Зураг 10.Төслийн талбайн ургамалжилтын зураг

Судалгааны талбайн ургамалжилтын бүлгэмдэл түүний төлөв байдал, өөрчлөлт, доройтол болон зүйлийн бүрэлдэхүүнийг тогтоох зорилгоор хээрийн судалгааг дараах аргазүйгээр гүйцэтгэсэн. Үүнд:

1.Бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг ажиглалт, бүртгэлийн аргаар, нэршлийг В.И.Грубовын \1982\ ангиллаар нэрлэсэн.

2.Бэлчээрийн ургамлын зүйлийн арвийг Друдейн нүдэн баримжааны аргаар тодорхойлсон. Энэ аргаар зүйлийн арвид үнэлгээ өгөхдөө дор дурьдсан тэмдэглэгээг хэрэглэнэ. Үүнд:

1. Soc- 75-100%-тухайн фитоцинозын хүрээнд бодгалийн тоогоор илт давамгайлах арви ихтэй ургамлууд

2. Сор3 - 50-75%- фитоцинозын хүрээнд нэлээд их арвитай байгаа урамал

3. Сор2 – 25-50%- ерөнхийдөө элбэг байгаа ургамлын арви

4. Сор1 – 5-25%- фитоцинозын хүрээнд цөөхөн тохиолдож байгаа ургамал,

Sol-5%- тоологдом цөөхөн арвитай ургамал

Un - < 1 буюу цорын ганц тохиолдох ургамал

3.Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэцийг Л.Г.Раменскийн аргаар тус тус тодорхойлсон.

Судалгааны үр дүн

Өмнөговь аймгийн Гурвантэс суман дахь “Чухам жаргалан” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд 12 овог, 24 төрөлд хамрах 33 зүйл ургамал бүртгэгдлээ.

Хүснэгт 12. Талбай орчмын ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүн

№	Ургамлын овог, төрөл, зүйлийн шинжлэх ухааны нэршил	Зүйл хамгааллын статус
1. <i>Ephedraceae</i> Dum. - Зээргэнийн овог		
1	<i>Ephedra</i> L.	
1	<i>Ephedra sinica</i> Stapf -Нангуад зээргэнэ	Ховор
2. <i>Gramineae</i> Juss. Үетэний овог		
2	<i>Aristida</i> L.	
2	<i>Aristida Heymannii</i> Rgl.-Гейманын бөөдий	Элбэг
3	<i>Achnatherum</i> P. B.	
3	<i>Achnatherum splendens</i> (Trin.) Nevski-Гялгар дэрс	Элбэг
4	<i>Ptilagrostis</i> Griseb.	
4	<i>Ptilagrostis Pelloitii</i> (Danguy) Grub.-Пеллитын шивэлз	Субэндемик
5	<i>Stipa</i> L.	
5	<i>Stipa glareosa</i> P.Smirn.-Сайрын хялгана	Элбэг
6	<i>Stipa gobica</i> Roshev.-Говийн хялгана	Субэндемик
6	<i>Enneapogon</i> Desv. ex P.B.	
7	<i>Enneapogon borealis</i> (Griseb). Honda.-Умардын огтонын сүүл	Элбэг
7	<i>Eragrostis</i> Wolf.	
8	<i>Eragrostis minor</i> Host-Бага хургалж	Элбэг
3. <i>Alliaceae</i> -Сонгинын овог		
8	<i>Allium</i> L.	
9	<i>Allium polyrrhizum</i> Turcz. ex RgL.-Таана буюу багалгар сонгино	Субэндемик
10	<i>Allium mongolicum</i> L.- Хөмүүл буюу Монгол сонгино	
4. <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог		

9	<i>Eurotia</i> Adans.	
11	<i>Eurotia ceratoides</i> (L.) C.A.Мей-Орог тэсэг	Элбэг
10	<i>Bassia</i> All.	
12	<i>Bassia dasyphylla</i> (Fisch.et Мей.) Ktze.- Үслиг манан-хамхаг	Элбэг
11	<i>Anabasis</i> L.	
13	<i>Anabasis brevifolia</i> C.A.Мей.-Ахар навчит баглуур	Элбэг
5. <i>Cruciferae</i> Juss. - Тоонолжинцэцэгтэний овог		
12	<i>Ptilotrichum</i> C. A. Мей.	
14	<i>Ptilotrichum canescens</i> C.A. Мей.-Бууралдуу янгиц	Элбэг
6. <i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог		
13	<i>Amygdalus</i> L.	
15	<i>Amygdalus pedunculata</i> Pall.-Барнулт бүйлээс	Элбэг
16	<i>Amygdalus mongolica</i> Maxim.-Монгол бүйлээс	Эндемик
7. <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтны овог		
14	<i>Caragana</i> Lam.	
17	<i>Caragana brachypoda</i> Pojark.-Хойрог харгана	Нэн ховор
15	<i>Oxytropis</i> DC.	
18	<i>Oxytropis aciphylla</i> Ldb.-Өргөст ортууз	Ховор
8. <i>Plumbaginaceae</i> Juss. - Хорголжингийн овог		
16	<i>Limonium</i> Mill.	
19	<i>Limonium tenellum</i> (Turcz.) Ktze.- Нарийн бэрмэг	Элбэг
9. <i>Verbenaceae</i> Jaume. - Догарын овог		
17	<i>Caryopteris</i> Bge.	
20	<i>Caryopteris mongolica</i> Bge.- Монгол догар	Эндемик
10. <i>Labiaceae</i> Lindl.- Уруул цэцэгтэний овог		
18	<i>Schizonepeta</i> Briq.	
21	<i>Schizonepeta annua</i> (Pall.) Schischk. - Нэг наст бивлэнцэр	Элбэг
19	<i>Lagochilus</i> Bge.	
22	<i>Lagochilus ilicifolius</i> Bge. -Ямаан ангалзуур	Субэндемик
11. <i>Bignoniaceae</i> Juss. -Тулмангийн овог		
20	<i>Incarvilla</i> Juss.	
23	<i>Incarvilla Potaninii</i> Batal.- Потанины улаан тулам	
12. <i>Asteraceae</i> Dumort. -Голгэсэрэтэний овог		
21	<i>Asterothamnus</i> Novopokr.	
24	<i>Asterothamnus centrali-asiaticus</i> Novopokr.-Төв Азийн лавай	Нэн ховор
25	<i>Asterothamnus poliiifolius</i> Novopokr.-Навчирхаг лавай	Ховор
22	<i>Ajania</i> Poljak.	
26	<i>Ajania acheleoides</i> (Turcz.) Poljak.-Төлөгчдүү боролз	Эндемик
23	<i>Artemisia</i> L.	
27	<i>Artemisia pectinata</i> Pall.-Шүлхий шарилж	Элбэг
28	<i>Artemisia scoparia</i> Waldst. et Kit.-Ямаан шарилж	Элбэг
29	<i>Artemisia xerophytica</i> Krasch.-Хуурайсаг шарилж	Субэндемик
30	<i>Artemisia xanthochroa</i> Krasch.-Шар шарилж	Нэн ховор
31	<i>Artemisia globosoides</i> .-Шардуу шарилж	Элбэг
24	<i>Scorzonera</i> L.	
32	<i>Scorzonera pseudodivaricata</i> Turcz.-Хуурамч дэрэвгэр хависгана	Эндемик
33	<i>Scrozonera capito</i> Maxim.-Данхар хависгана	Субэндемик
12 овог, 24 төрөл, 33 зүйл		

“Чухамжаргалан” ХХК-ийн уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд ургаж байгаа нэн ховор, ховор, унаган, үлдэц ургамлын бүртгэлийг гаргахад:

нэн ховор ургамал Хойрог харгана (*Caragana brachypoda* Pojark.), Потанины улаан тулам (*Incarvilla Potaninii* Batal.), Төв Азийн лавай (*Asterothamnus centrali-asiaticus* Novopokr.), Шар шарилж (*Artemisia xanthochroa* Krasch.), нийт 3 овогт хамаарах 4 төрлийн 4 зүйл ургамал ургаж байна.

Ховор ургамал. Нангиад зээргэнэ (*Ephedra sinica* Stap.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla*)

Ldb.), Монгол бүйлээс (*Amygdalus mongolica* Maxim.), Навчирхаг лавай (*Asterothamnus polyifolius* Novopokr.) нийт 4 овгийн 4 төрлийн 4 зүйл ,

Монголын унаган (эндемик) ургамал. Монгол догар (*Caryopteris mongolica* Bge.), Төлөгчдүү боролзой (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), Хуурамч дэрэвгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.) зэрэг 3 овгийн 3 төрлийн 3 зүйл,

Монголд байгаа завсарын унаган ургамал (субэндемик) (Пеллитын шивэлз (*Ptilagrostis Pelloitii* (Danguy) Grub.), Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), Ямаан ангалзуур (*Lagochilus ilicifolius* Bge.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.) , Ороолдоо шарилж (*Artemisia intricata* Franch.), Бөндгөр шарилж (*Artemisia sphaerocephala* Krasch.), Данхар хависгана (*Scorzonera capito* Maxim..) зэрэг 4 овгийн 6 төрлийн 8 зүйл бүртгэгдсэн байгаа нь бүх ургамлын 43.17% нь хамгаалалтанд авах шаардлагатай ургамалд багтаж байна.

Төслийн талбайн ургамалжил

Өмнөговь аймгийн Гурвантэс суман дахь “Чухам жаргалан” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд 2 бичиглэл хийхэд дараах үндсэн 2 бүлгэмдэлд хуваагдаж байна. Үүнд:

- Тэсэг –боролзой-шавагт, холимог сөөгт (74 -76/У-VII-2-1; У-VII-2-3)
- хотирт –холимог сөөгт (243/ Н-V-3-1) бүлгэмдэл байна.

Хад чулуутай жижиг уулсаараа Тэсэг –боролзой-шавагт, холимог сөөгт, түүний хөндийгөөр Шарилж –шаваг –холимог сөөгт бүлгэмдэлтэй.



Зураг 11. Төслийн талбайн ерөнхий төлөв

1.Тэсэг –боролзой-шавагт, холимог сөөгт (74 -76/У-VII- 2-1; У-VII-2-3)



Зураг 12. Төслийн талбайн доторх ургамал бичиглэл №1

Тус талбай нь Гурван тэс сумын өмнө байрлах нам уулын хажуу, хөндийгөөр тархах бөгөөд Тэсэг –боролзой-шавагт, холимог сөөгт бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 5%, 23 зүйлийн ургамал ургасан, 1м²-д 3-5 орчим зүйл тааралдаж (бичиглэл-1) бүртгэгдсэн, ургац 0,6 ц/га байсан. Сөөг 50-80 см өндөртэй, өвслөг ургамлын 5 см өндөртэй байсан. Ус урсах хсэгээр шарилжит бүлгэмдэл үүссэн. Зонхилогч ургамлын хувьд үетнээс сайрын хялгана, алаг өвснөөс таана, монгол сүүт өвс, зэлэн зангуу, сөөгнөөс Монгол бүйлс, Монгол догар, цагаалин харгана, орог тэсэг, шар модот хотир ургана. Бэлчээрийн талхагдал бага. Судалгааны үед гандуу байсан.

Хүснэгт 13. Бичиглэл -1

Ургамлын зүйлийн бүрдэл					
№	Ургамлын латин нэр	Ургамлын монгол нэр	Бүрхэц, %	ангилаа	Ашигт ургамал
1	<i>Ajiana trifida</i>	Гурвалсан салбант боролз	1	бэлчээр	
2	<i>Allium mongolicum</i>	Хөмүүл		бэлчээр	элбэг
3	<i>Allium polyrrhizum</i>	Таана	1	бэлчээр	элбэг
4	<i>Amygdalus pedunculata</i>	Бариулт бүйлээс	1	бэлчээр	элбэг
5	<i>Anabasis brevifolia</i>	Ахар навчит баглуур		бэлчээр	элбэг
6	<i>Artemisia globosoides</i>	Шардуу шарилж		бэлчээр	
7	<i>Caryophyteris mongolica</i>	Монгол догар		бэлчээр	элбэг
8	<i>Dracocephallium foetidum</i>	Үмхий шимтэглээ	1	бэлчээр	элбэг
9	<i>Euphorbia mongolicum</i>	Монгол сүүт өвс		бэлчээр	элбэг
10	<i>Karshinikovia ceratoides</i>	Орог тэсэг		бэлчээр	
11	<i>Stipa glauca</i>	Сайрын хялгана	1	дүүргэгч	элбэг
12	<i>Tribulus terrestris</i>	Зэлэн зангуу		бэлчээр	элбэг
13	<i>Zygophyllum xanthoxylon</i>	Хотир		бэлчээр	элбэг
14	<i>Caragana brachypoda</i> Pojark.-	Хойрог харгана		бэлчээр	элбэг
15	<i>Limonium tenellum</i>	Нарийн бэрмэг		бэлчээр	элбэг
16	<i>Peganum harmala</i>	Эгэл өмхий өвс		бэлчээр	
17	<i>Asparagus gobicus</i>	Говийн хэрээннүд	*	бэлчээр	элбэг
18	<i>Oxytropis aciphylla</i>	Өргөст ортууз		Бэлчээр	ховор
19	<i>Convolvulus ammonii</i>	Аммоний сэдэргэнэ	1	бэлчээр	элбэг
20	<i>Ephedra sinica</i>	Нангиад зээргэнэ		бэлчээр	элбэг
21	<i>Asterothamnus polyfolius</i>	Навчирхаг лавай		бэлчээр	ховор
22	<i>Scrozonera capito</i>	Данхар хависгана		бэлчээр	элбэг
23	<i>Incarvilla Potaninii</i>	Потанины улаан тулам		бэлчээр	Нэн ховор

2.Хотирт –холимог сөөгт (243/ Н-V-3-1)



Зураг 13. Төслийн талбайн доторх ургамал бичиглэл №2

Тус талбай нь замын трасс дагуу тэгш хөндийгөөр тархах бөгөөд цөлийн хотирт бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 20%, 10 зүйлийн ургамал (бичиглэл-2) бүртгэгдсэн, ургац 0,4 ц/га байсан. Өвслөг ургамлын 5 см өндөртэй, сөөг 60 хүртэл см өндөртэй байсан. Зонхилогч ургамлын хувьд үетнээс сайрын хялгана, алаг өвснөөс хөмүүл, таана,алтайн согсоолж, ширэг улалж, сөөгнөөс регелийн будраа, улаан бударгана, цагаан харгана, шар хотир ургана. Бэлчээрийн талхагдал бага. Гандуу байсан.

Хүснэгт 14. Бичиглэл -2


Ургамлын зүйлийн бүрдэл					
№	Ургамлын латин нэр	Ургамлын монгол нэр	Бүрхэц, %	ангилаа	Ашигт ургамал
1	<i>Caragana stenophylla</i>	Нарийн навчит харгана	2	бэлчээр	элбэг
2	<i>Reamurea songorica</i>	Улааг бударгана	1	бэлчээр	
3	<i>Carex duriuscula</i>	Ширэг улалж	*	бэлчээр	элбэг
4	<i>Stipa glauca</i>	Сайрын хялгана	1	бэлчээр	элбэг
5	<i>Allium mongolicum</i>	Хөмүүл	3	бэлчээр	элбэг
6	<i>Allium polyrrhizum</i>	Таана	1	бэлчээр	элбэг
7	<i>Bassia dasyphylla</i>	Манан хамхаг	*	дүүргэгч	элбэг
8	<i>Heteropappus altaicus</i>	Алтайн согсоолж	1	бэлчээр	элбэг
9	<i>Sympegma regellii</i>	Регелийн будраа, шар мод	3ш	бэлчээр	
10	<i>Zygophyllum xanthoxylon</i>	Шар хотир	8ш	бэлчээр	элбэг

Ургамлан нөмрөгийн ашиглалт, доройтлын өнөөгийн түвшин

Төсөл хэрэгжих орчны нутаг дэвсгэр нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших ба ургамлан бүрхэвч нь байгалийн хүчин зүйлсээс илүүтэйгээр антропогены нөлөөгөөр ургамлын төрөл зүйл хомсодсон. Төсөл хэрэгжүүлэгч талаас ногоон байгууламж бүхий мод сөөг ургуулж, арчлах шаардлагатай байна. Уг төслийн газрын гадарга дээр хөрсний талхагдал үүссэн, одоогийн байдлаар бор бударгана болон шар модот хотир дунд зэрэг тархмал ургасан байна.




Зураг 14. Төслийн талбай дахь ургамалжилтын байдал-Шар модот хотир ургасан байдал



Зураг 15. Судалгааны талбайн ургамалжилтын төлөв байдал



Зураг 16. Төслийн талбайн бодит зураглал №1



Зураг 17. Төслийн талбайн бодит зураглал №2



Зураг 18. Төслийн талбайн бодит зураглал №3




Зураг 19. Төслийн талбайн бодит зураглал №4

2.5 Гадаргын ус

Төслийн талбай байрлах бүс нутаг нь Монгол орны гадаргын усны ангиллаар Төв

Азийн гадагш урсгалгүй ай сав, сав газрын ангилалаар Алтайн өвөр говийн сав газарт тус тус хамаарагдана. Төслийн талбайн хэмжээнд гадаргуугийн ил урсац, булаг, шанд, рашаан болон гол горхи байхгүй болно.

Хөвийн барилгын чулууны ордын энэхүү геологи-хайгуулын талбай нь Монгол орны говь цөлийн бүсэд орших учир эх газрын эрс, тэс уур амьсгалтай нутагт хамаарагдана. Энд жилд унах хур тунадас багавтар, ууршилт нь түүнээс давдаг.



Зураг 20.Төслийн талбайн сав газрын зураглал

Усан хангамжийн хүрэлцээ. Өмнөговь аймгийн хүн амын 70.1 хувь нь шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ хүртэж байгаа бөгөөд улсын хэмжээнд 10-д эрэмбэлэгдэж байна. Аймгийн хэмжээнд аймгийн төв Даланзадгад сумын хүн амын 97.6, Ханбогд сумын 70.1, Цогтцэций сумын 88.1 хувь нь шаардлага хангасан усны эх үүсвэрээр хангагдаж байгаа ба МХЗ-ын түвшинд хүрсэн байна. Бусад сумдын ундны усны гол эх үүсвэр нь хамгаалагдсан худаг байна.

Хүснэгт 15. Өмнөговь аймгийн шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ

Сумдын нэр	Шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ хүртэж байгаа хүн амын эзлэх хувь	Төвлөрсөн ус хангамжийн сүлжээнээс усаа авдаг хэрэглэгч	Ус түгээх байр		Зөөврийн ус	Хамгаалагдсан худаг	Хамгаалагдсан булаг шанд
			Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	Төвлөрсөн системд холбогдоо-гүй ус түгээх байр			
	PPimp	N ₁	N _{2a}	N _{2b}	N _{2c}	N ₃	N ₄
Аймгийн	70.1	20.7	29.1	0.9	3.2	14.2	2.0


дүн:							
Даланзадгад	97.6	15.7	75.7	1.3	1.3	3.5	0.1
Баяндалай	33.9	2.5	26.2	0.0	1.1	4.0	0.1
Баян-Овоо	46.5	26.4	0.0	0.0	7.5	12.3	0.3
Булган	49.2	0.1	0.6	0.2	0.0	5.1	43.1
Гурвантэс	56.8	34.7	0.4	0.2	0.6	19.0	1.9
Мандал-овоо	53.0	0.3	0.7	0.0	0.3	51.1	0.7
Манлай	45.4	0.0	0.7	0.0	0.0	44.3	0.5
Ноён	35.4	0.0	0.0	0.0	1.1	34.3	0.0
Номгон	25.4	23.7	0.0	0.0	0.0	1.5	0.2
Сэрвэй	37.5	0.0	0.0	0.7	1.0	35.7	0.1
Ханбогд	70.4	42.3	0.8	1.2	22.3	3.5	0.3
Ханхонгор	36.8	0.0	0.2	1.0	0.7	33.7	1.1
Хүрмэн	39.5	16.7	1.9	0.0	3.7	16.9	0.3
Цогт-Овоо	47.4	24.1	0.5	2.7	0.0	20.2	0.0
Цогтцэций	88.1	55.2	0.5	1.4	4.4	26.3	0.4

Аймгийн нийт хүн амын 29,9 хувь шаардлага хангаагүй усны эх үүсвэр хэрэглэж байгаа бөгөөд ихэнх сумын хүн амын 50-аас дээш худаг нь гар худаг, булаг шанд, гол горхины ил задгай ус хэрэглэдэг байна.

2.6 Газар доорхи ус

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших орд газарт газрын доорх усны 4 уст цогцолбор тархсан (БОННУ, 2012)

- ✚ Дөрөвдөгчийн үеийн уст цогцолбор (Q)
- ✚ Дунд дээд триасын хурдасын уст цогцолбор (T2-3 no)
- ✚ Дунд цэрдийн баруун гоёотын уст цогцолбор (K2bg)
- ✚ Дээд пермийн хурдасын уст цогцолбор (P2 ds)



Зураг 21. Төслийн талбайн орших цэвдгийн бүслүүр

Дөрөвдөгчийн үеийн уст цогцолбор (Q) нь уулын бэл хормой, голын хуурай сайрын хэсгээр тархсан ба бал чулуу, хайрга, янз бүрийн ширхэгтэй элс элсэнцэр, шавранцар, шавраас бүрдэнэ. Энэ хурдасууд нүх сүв давхаргын коллектор шинжтэй. Химийн найрлагаараа гидрокарбонат-сульфатлиг, натри-магнийн төрлийн ус. Цэнгэг устай 0.7 г/л эрдэсжилттэй, хатуулаг 2.7-4.4 мг-экв/л.

Дунд дээд триасын хурдасын уст цогцолбор (T2-3 no) нь дунд дээд триасын уст цогцолбор нь талбайн төв ба зүүн хэсгээр тархсан. Ус агуулагч чулуулаг нь элсэн чулуу, жижиг дунд хэмжээтэй хайргатай хөрзөн чулуу, карбонатлаг барьцуулагчтай элсжин, зануужингаас бүрдэнэ.

Эдгээр хурдасуудад ан-цав, ан-цав давхаргын ус тархсан. Химийн найрлагаараа холимог, Гидрокарбонат-хлор-сульфатлаг, натри-кальци-магнийн ус зонхилж тархсан. Усны хатуулаг 0.9-30.6 мг-экв/л. Талбайн хэмжээнд сулавтар шүлтлэг орчин тархсан бөгөөд рН үзүүлэлт жигдэвтэр 7-8 байна.

Дунд цэрдийн баруун гоёотын уст цогцолбор (K2bg) нь талбайн хойт ба урд хэсэгт бага зэрэг тархсан. Ус агуулагч чулуулаг нь улаавтар өнгөтэй элсэн чулуу, алевролит, шавар, гравилит, хөрзөн чулуулагаас тогтоно. Энэ уст цогцолборын уст үеүд нь 37-70 метрийн гүнд илрэх ба ан-цав, ан цав давхаргын ус агуулдаг. Сулавтар усжсан.

Энэ уст цогцолбор тархсан талбайд өрөмдсөн ZU-07-03 цооногт хийсэн шавхалтын дүнгээс үзэхэд түвшингийн 17 метрийн бууралтад 0.3 л/с ундарга өгч байгаа нь сул усжсаныг харуулж байна. Химийн найрлагаараа холимог, гидрокарбонат-хлор-сульфатлаг, натри-кальци-магнийн төрлийн ус зонхилж тархсан. Усны хатуулаг 1.2-30.6 мг-экв/л. Талбайн хэмжээнд сулавтар шүлтлэг орчин тархсан бөгөөд рН үзүүлэлтүүд жигдэвтэр 7 байна.

Дээд пермийн хурдасын уст цогцолбор (P2 ds) нь талбайн хойд хэсэгт нүүрсний гарш орчимд бусад хэсэгт 300м гүнд тархсан. Ус агуулагч чулуу нь элсэн чулуу, жижиг дунд хэмжээтэй хайргатай хөрзөн чулуу, карбонатлаг барьцуулагчтай элсжин, зануужингаас бүрдэнэ. Химийн найрлагаараа холимог сульфат-гидрокарбонат-хлорын, сульфат-хлор-гидрокарбонатын натрийн-кальц-магнийн төрлийн ус зонхилон тархсан. Эрдэсжилт харьцангуй өндөр 1.3-5.4 г/л үзүүлэлттэй. Түүний хатуулаг 12 мг-экв/л-ээс дээш, маш их хатуулагтай.

2.7 Амьтны аймаг

Амьтны газар зүйн мужлалаар Алтайн өвөр говийн тойрогт хамаарах бөгөөд сайр садаргаар ихээхэн хэрчигдсэн харгана, буйлст хайрга чулуурхаг зарим хэсэгт хужир мараа бүхий дэрс, түнгэт хотгортой, хармагын довт уужим хөндий бүхий янз бүрийн биотоптой, хур тунадас элбэг үед тогтинги ус, нуур шал элбэг, шавартай байдаг онцлогтой.

Хээрийн судалгаа болон урд өмнө хийсэн судалгаа, ном бүтээлээс магадлахад Алтайн өвөр говийн тойрог орчимд 7 багийн 30 зүйлийн хөхтөн амьтад байршин нутагладаг болохыг тогтоолоо.

Хүснэгт 16. Алтайн өвөр говийн тойрогт тохиолдох хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл

	Зүйлийн нэр	Шинжлэх ухааны нэр	IUCN Red List (2006) Global category	Монгол ховор амьтны жагсаалт 2012	Улсын амьтны жагсаалт 2012	Монгол Улаан ном, CITES I, II хавсралт	Улаан данс (2006)	Амьтны тухай хууль 2012	Агнуурын холбогдолтой
ТУРУУТАН - ARTIODACTYLA									
1	Хар сүүлт	<i>Gazella subgutturosa</i>	ЭМ	+	+		ЭМ		+
2	Аргаль хонь	<i>Ovis ammon</i>	ЭМ	+	+	II	УБ		+
3	Янгир ямаа	<i>Capra sibirica</i>	АӨ	+	+		ХБ		+
4	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	АӨ	-	-		ХБ		+
ТУУРАЙТАН – PERISSODACTYLA									
5	Хулан адуу	<i>Equus hemionus</i>	ЭМ	+	+	I	УБ		+
МАХЧТАН – CARNIVORA									
6	Говийн шүлүүс мий	<i>Lynx lynx isabellina</i>	ХБ	+	+	II	ХБ		+
7	Мануул мий	<i>Otocolobus manul</i>	ХБ			II	ХБ		+
8	Саарал чоно	<i>Canis lupus</i>	АӨ			II	ХБ		+
9	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	АӨ			-	ХБ		+
ТУУЛАЙТАН – LAGOMORPHA									
10	Бор туулай	<i>Lepus tolai</i>	АӨ	-	-	-	АӨ		+
11	Үхэр огдой	<i>Ochotona pallasii</i>	АӨ	-	-	-	АӨ		
ЗАРААТАН – ERINACEI									
12	Дэлдэн зараа	<i>Hemiechinus auritus</i>	АӨ	-	-	-	АӨ		
ДАЛАВЧТАН – CHIROPTERA									
13	Говийн сармаахай	<i>Eptesicus gobiensis</i>	АӨ				АӨ		
14	Борхон турсаахай	<i>Hypsugo savii</i>	АӨ				МД		
15	Сахалт багваахай	<i>Myotis mystacinus</i>	АӨ				АӨ		
16	Том соотон багваахай	<i>Plecotus austriacus</i>	АӨ				МД		
17	Буурал сармаахай	<i>Vespertilio murinus</i>	АӨ				АӨ		
МЭРЭГЧТЭН – RODENTIA									
18	Сибирь алагдаага	<i>Allactaga sibirica</i>	АӨ	-	-	-	АӨ		
19	Говийн алагдаага	<i>Allactaga bullata</i>	ХБ				МД		
20	Хадны барагчин	<i>Alticola semicanus</i>	АӨ				АӨ		
21	Таван-хуруут атигдаахай	<i>Cardiocranius paradoxus</i>	ЭМ	-		-	МД		
22	Элсний зусаг	<i>Phodopus roborovskii</i>	АӨ				АӨ		
23	Цомч шишүүхэй	<i>Allocricetulus curtatus</i>	АӨ				АӨ		
24	Өөхөн-сүүлт атигдаахай	<i>Salpingotus crassicauda</i>	ЭМ				МД		
25	Элсч савагдаахай	<i>Dipus sagitta</i>	АӨ				АӨ		
26	Монголжин даахай	<i>Stylodipus andrewsi</i>	АӨ				АӨ		
27	Бүрдэн шишүүхэй	<i>Cricetulus sokolovi</i>	АӨ				МД		
28	Элсний зусаг	<i>Phodopus roborovskii</i>	АӨ	-	-	-	АӨ		
29	Түвд ов	<i>Eolagurus przewalskii</i>	АӨ				МД		
30	Шаргал чичүүл	<i>Merionus meridianu</i>	АӨ	-	-	-	АӨ		
				5	5	5			9

Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдал

-Оршин суугчид нөлөөллийн бүсийн дотор талд 1айлын эзэмшил оршино. Тус айл нь сүүлийн жилүүдэд суурьшихгүй байгаа. Мөн ямар нэгэн байгууламжгүй. Цаашид суурьшил хийсэн тохиолдолд оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор өгөх, харилцан тохиролцоо хэрэгтэй.

-Төсөл хэрэгжсэнээр ажлын байр бий болж, нутгийн иргэд ажилд орно.

Уурхайгаас олборлож, бутлан ангилсан дайргыг “Мэргэн Хангал” ХХК, “Очир-Өргөө” ХХК, “Бласт” ХХК, “Пауэр Бласт” ХХК, “Өсөх Зоос Алтан Говь” ХХК болон бусад орон нутгийн компаниудад худалдана. Бүтээгдэхүүний борлуулах үнэ 5÷10мм –ийн хэмжээтэй дайрганд 1 м3 нь 34,000 төгрөг, 10÷20 болон 20÷40мм –ийн хэмжээтэй дайрганд 1 м3 нь 50,000 төгрөг тус тус байна.

Ашиглалтын 4 жилийн хугацаанд нийт 505.6 мян.м3 дайрга борлуулж 25.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 21.7 тэрбум төгрөгийн зардал гаргахаар байна. Мөн нийт хуримтлагдсан мөнгөн урсгал 2.03 тэрбум төгрөг, дискаунтын түвшинг жил бүр 10%-р тооцоход дискаунтлагдсан мөнгөн урсгал буюу ирээдүйн мөнгөний одоогийн үнэ цэнэ NPV=1.12 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын өгөөжийн дотоод норм 34%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 2.05 жил болж байна.

Төсөл хэрэгжих нийт хугацаанд улс, орон нутгийн төсөвт 5.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр байна.

Түүх соёлын дурсгалт зүйлс, тусгай хамгаалалттай газар нутаг

Палеонтологи хайгуул, судалгааны ажлын дүгнэлт. Тус ордын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд палеонтологийн судалгааг ШУА-ийн палеонтологи, геологийн хүрээлэнгийн баг хамт олноор 2017 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр гүйцэтгүүлсэн. Тус ажлыг явуулахдаа Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 8 дугаарт заасны дагуу ажилласан байна.

Судалгааны талбайн хэмжээнд протерозойн цаг үеийн метаморф /хувирмал/ чулуулаг тархсан ба эртний амьтан ургамлын үлдвэр илрээгүй байна.

Цаашид тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд ашиглалт явуулах үе шатанд палеонтологийн сонирхолтой үнэт ховор олдвор илэрсэн тохиолдолд олборлолтын ажлыг түр зогсоож холбогдох байгууллагуудад хандан авран хамгаалах малтлага хийлгэх хэрэгтэй гэж үзсэн байна. Тус судалгаа шинжилгээний ажлын дэлгэрэнгүйг хавсралт материалаар хавсаргав.

Түүх-Археологийн авран хамгаалах судалгааны ажлын дүгнэлт. Тус ордын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27.8, 27.9, болон Соёлын өвийн судалгаа хийх журмын 2 дугаар бүлгийн 2.1.2 болон 3.1 зэрэг заалтуудыг баримтлан тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд тархсан эртний булш болон эртний түүх соёлын хөшөө дурсгалуудыг тогтоолгох зорилгоор Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын археологи-угсаатны зүйн судалгааны багийн нэр бүхий судлаачдаар 2017 оны 09 сарын 23-26-ны өдөр хүртэл нийт 3 хоногийн хугацаанд археологийн судалгааг гүйцэтгүүлсэн. Тус ажлын үр дүнд хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайгаас археологийн олдвор илрээгүй.

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17.10, 17.12, болон “Монгол улсын нутаг дэвсгэр дээр археологи, палеонтологийн хайгуул,

малталгаа судалгаа хийх журам"-ын 2.4, 2.5 дугаар заалтуудыг үндэслэн түүх-археологийн дурсгалын хадгалалт хамгаалалтанд анхааран, хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаа явуулах тохиолдолд хэрвээ дурсгал илэрвэл малтан судалж, талбайг чөлөөлүүлэх шаардлагатай хэмээн үзсэн байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Улсын ТХГН-ийн хувьд: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт хэрэгжиж буй тус ордын талбайн хувьд Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг хамаарагдахгүй байна. /Зураг 15-ээс харж болно/

Орон нутгийн ТХГН-ийн хувьд: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт хэрэгжиж буй тус ордын талбайн хувьд Орон нутгийн Тусгай хамгаалалттай газар нутаг хамаарагдахгүй байна. /Зураг 15-ээс харж болно/

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 67 тоот тогтоолоор “Өмнөговь аймгийн есөн гайхамшиг”-ийг тодруулан батламжилсан байдаг. Үүнээс Гурвантэс суманд Говь гурван сайхан уул болон Толь хад, Ноён богд багтаж байна.

- Хонгорын элс- Зүүн шургуул, Баруун шургуул
- Баянзаг- Цахиуртын хөндий, Төгрөгийн ширээ
- **Говь гурван сайхан уул- Ёлын ам, Дүнгэнээ, Мухар шивэртийн ам**
- Нэмэгт, Хэрмэн цав- Зуун мод, Зулганай, Наран даац
- **Ноён богд, Толь хад- Саран хөндий, Гурван түшмэл**
- Алгуй улаан цав- Сэврэй хайрхан, үлэг гүрвэлийн яс, Тогоонтөмөр хааны ордны буурь
- Галбын говь- Галбын гурван хийд, Ундайн гол, Ханбогд хайрхан, Мэлхий цохио, Ловон чомбын агуй, Шар цавын үлэг гүрвэлийн мөр
- Сангийн далай хийд
- Ноён, Сэврэй хийцийн мөнгөн эдлэл

Говь гурван сайхан

Ёлын ам нь аймгийн төвөөс баруун тийш 56 км-т Зүүнсайхан ууланд байрлалтай Говь гурвансайханы байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүсэд багтдаг байгалийн үзэсгэлэнтэй газар нутаг юм. Ёлын амыг 1965 онд дархан цаазат газар болгох АИХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гарснаар Говийн экосистемийг хамгаалах асуудлын үндэс тавигдсан бөгөөд 1993 онд Ёлын амны дархан цаазат газрыг өргөжүүлж, 1993 онд ГГСБЦГ болгосон.

Ноён богд, Толь хад


Толь хад, Саран хөндий, Гурван түшмэл, Ханын хэц, Цагаан ханын агуй гэх мэт Ноён сумын нутагт орших байгалийн үзэсгэлэнт газрууд орно.

Тост, Тосон бумбын нурууны БНЦГ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, Тосон бумбын нурууны Байгалийн нөөц газрыг 153482.37 га талбайгаар нэмэгдүүлэн нийт 896540.37 га талбайгаар хилийн заагийг шинэчлэн тогтоохоор шийдвэрлэсэн байна. Энэхүү талбайг Улсын тусгай хамгаалалтад авснаар Тост, Тосон бумбын нурууны 869540.47 га газар хамарч байна.

Тост, Тосон Бумбын нуруу нь аймгийн төв Даланзадгад хотоос баруун зүгт 308 км зайд, Гурвантэс сумаас баруун тийш 40 км зайд, Гурвансайханы байгалийн цогцолборт газрын хилээс 25 км зайд, өмнө талаараа улсын хилд тулж, хойд талаараа Нэмэгтийн нуруу болон Алтан уул зэргээс өргөн хөндий, хоолойгоор тусгаарлагдан оршдог. Тост, тосон бумбын нуруунд усан хагалбар зэргэлдээх уул хоорондын хөндийн газар доорх усны тэжээлийн гадаад муж давхцан оршдог. Иймээс энэ нуруунд бүрэлдэж байгаа урсац Хөвд орчмын булаг шанд, баян бүрдүүд цаашлаад Хуршуутын гол, Нарийн сухайт орчмын олон тооны худаг ус булаг шандыг тэжээж байдаг учир уул уурхайн ашиглалтын явцад хатаж ширгэх, устаж үгүй болох аюул нүүрлээд байсан юм.

Судалгааны талбайгаас 35 км орчим зайтай Өмнөговь аймгийн Гурвантэс сумын дамнан орших Улсын ТХГН болох Говь гурван сайхан уул хамгийн ойр оршиж байна.



Зураг 22. Төслийн талбайн ойролцоохи улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн байршил

2.8 Сум орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал

Гурвантэс сүм, сүмийн хөгжил

Гурвантэс сумын түүх, уламжлал

Сумын үүсэл, хөгжлийн түүх. Гурвантэс сум нь 1954 онд анх Тост нэртэйгээр одоогийн Сэврэй сумын 1 дүгээр баг, Ноён сумын 3, 4, 5 дугаар багууд нийлж Улаан толгой гэдэг газар 281 өрх, 943 хүн амтай, 63,2 мянган малтай байгуулагджээ. 1959 онд орон даяар нэгдэлжих хөдөлгөөн ялсаны үрээр, 1960 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Гурвантэс сум гэж нэрлэгдэн, одоогийн байрлаж байгаа Уртын

дэнжид төвлөрсөн байна.


Уламжлалт ахуй. Нүүдэлчин нийгмийн ахуй болоод хөдөлмөрийн харилцааны ялгаатай байдал хөдөөгийн оршин суугчдын дунд одоо ч хадгалагдсаар байгаа орчин бол говийн бүс нутаг. Эрчүүд нь мал хариулах, ан гөрөө хийх, хашаа саравчаа засах, худаг ус гаргах зэрэг гэрийн гадна ажлыг амжуулах бол эмэгтэйчүүд нь сааль сүүгээ боловсруулах, гэрийн доторх аж ахуйгаа эрхэлж угаах, оёх, хүүхдээ харж асрах зэрэг ажлаа хийсээр байна. Бэлчээрийн уламжлалт мал аж ахуй эрхлэх хөдөөгийн амьдралын үндсэн гол хэлбэр нь худаг, уст цэг бараадсан амьдралын хэв шинж мөн юм.

Нийтлэг хэлбэр гэр бүл угсаа, овог аймаг, холбоо зэрэг зохион байгуулалтад орж ирсэн бөгөөд энэ нь нийгмийн хөгжил тогтвортой биш болох үед ямар ч зохион байгуулалтад богино хугацаанд орох боломжтой байдгаараа онцлогтой. Улсын хэмжээнд үйлдвэржилт, эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийн хувьсалд амархан шинэчлэгдэн өөрчлөгдсөөр ирсэн ч Нүүдэлчин өв соёлын түүх уламжлалыг хадгалсаар байгаа юм.

Аж ахуй. Засаг захиргааны анхан шатны нэгж болох 5 багтай. Малчин 1105 өрхийн 906 нь мал бүхий, 199 нь малчин өрхтэй. 2022 оны жилийн эцсийн мал тооллогоор 173.6 мян толгой мал тоолуулснаас тэмээ-8.57 мян, адуу-3.32 мян, үхэр-0.59 мян, хонь-11.29 мян, ямаа-149.85 мян тус тус тоологдсон. Сумын төвд төсөвт 6 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3 үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна холбооны салбар, ХААН банк, Төрийн банк, Капитрон банк, Гялс төгрөг хадгаламж зээлийн хоршоо, цаг уур, шуудан холбоо, Өмнөд бүс цахилгаан түгээх сүлжээ ХХК, НИК ШТС, Хөрс ШТС, МТ ШТС зэрэг хувийн хэвшлийн байгууллагууд ажиллаж байна.

Нийтлэг хэлбэр гэр бүл угсаа, овог аймаг, холбоо зэрэг зохион байгуулалтад орж ирсэн бөгөөд энэ нь нийгмийн хөгжил тогтвортой биш болох үед ямар ч зохион байгуулалтад богино хугацаанд орох боломжтой байдгаараа онцлогтой. Улсын хэмжээнд үйлдвэржилт, эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийн хувьсалд амархан шинэчлэгдэн өөрчлөгдсөөр ирсэн ч Нүүдэлчин өв соёлын түүх уламжлалыг хадгалсаар байгаа юм.

Хүн ам. 2022 оны байдлаар Гурвантэс сумын нийт хүн ам 5300 байна. Үүнээс 1-р баг 1004, 2-р баг 1041, 3-р баг 1143, 4-р баг 1464, 5-р баг 648 хүн амтай байна.



Зураг 23. Гурвантэс сумын 2017-2022 оны хүн амын мэдээ харьцуулалт, сум багаар харууллаа

Уул уурхай. Гурвантэс сумын өмнөд хэсэгт коксжих нүүрсний томоохон уурхайнууд бий. Эндээс БНХАУ улс руу жилдээ 5 сая хүртэл тонн коксжих нүүрс экспортолж байна.

Гурвантэс сумын газар нутаг, ашиглалт

Сумын газар нутгийн хэмжээ. Өмнөговь аймаг нь 165.0 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй ба түүний 15 хувийг Гурвантэс сум эзэлж аймгийн хэмжээнд газар нутгийн хэмжээгээрээ 1 дүгээрт жагсаж байна.

Гурвантэс сум нь нийт 2796.7 мянган га нутаг дэвсгэртэй ба 2022 оны байдлаар сумын нийт нутгийн 24.0 хувь нь ХАА-н газар буюу бэлчээрээрээ байна.

Хүснэгт 17. Гурвантэс сумын нийт нутгийн хэмжээ, Газрын нэгдсэн сангийн ангиллаар, 2022 он


№	Үндсэн ангилал	Талбайн хэмжээ	
		Га-аар	%-аар
1	Хөдөө аж ахуйн газар	686971.338	24
2	Хот, тосгон болон бусад суурин газар	7602.51	0.27
3	Зам, шугам сүлжээний газар	541256	19.35
4	Ойн сан бүхий газар	721857	25.81
5	Усны сан бүхий газар	13656	0.48
6	Улсын тусгай хэрэгцээний газар	12234	0.43
Нийт талбай		2796776	100.0

Газар ашиглалт. Гурвантэс сумын газар ашиглалтын гол хэлбэр нь ХАА-н эдэлбэр газар бөгөөд сумын хэмжээнд нийт 664,823.468 га газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглаж байгаагийн 72.2 хувийг зун-намрын, 27.8 хувийг хавар-өвлийн бэлчээрт ашиглаж байна.

Хүснэгт 18. Гурвантэс сумын ХАА-н эдэлбэр газрын ашиглалт, 2022 он

Үндсэн ангилал	Газрын үндсэн ангиллын		Талбай, га	
	1-р төвшин	2-р төвшин	Га-аар	%-аар
ХАА-н газар	Бэлчээр	өвөл хаврын	184634.700	27.8
		зун намрын	480188.7680	72.2
	Тариалан		27900	4.01
	ХААН-н барилга		299.9700	0.04
	ХАА-д тохиромжгүй		5752.08	0.8
Нийт ХАА-н газар			686971.338	100.0

Тус сумын бэлчээрийн ургацын олон жилийн дунджийг 1.45 ц/га гэж үзвэл жилийн дундаж бэлчээрийн нөөц 889.2 мянган ц/га болох ба энэ 211.7 мянган хонь толгой мал



бэлчээх боломжит нөөц байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар Гурвантэс суманд нийт 159.3 мянган толгой мал тоологдсон бөгөөд хонь толгойд шилжүүлснээр 224.7 мянган хонь толгой болж байгаа нь боломжит бэлчээрийн даацаас 1.4 хувиар хэтэрсэн байна. Одоо ашиглаж байгаа бэлчээрийн хэсгээр

даацыг тооцож үзсэнээр бэлчээрийг Гоёот баг 31.05 хувь, Баясах баг 41.68 хувь, Тост баг 31.67 Урт 23.6 Бага-Овоо баг 21.7 хувьтайгаар тус тус ашиглаж байна.

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлтөөс үзэхэд нийт бэлчээрийн 51.2 хувь 229543.3 га бага талхлагдсан, 15.2 хувь 68444.28 дунд зэрэг талхлагдсан, 21.7 хувь буюу 97370.1 га нь их талхлагдсан, 6.6 хувь буюу 29879.29 га нь алслагдсан, 5.06 хувь буюу 22709.89 га нь техногений нөлөөнд орсон байна.

Гурвантэс сумын хэмжээнд нийт 7602.51 мянган га талбайг хот, тосгон болон суурин газрын зориулалтаар ашиглаж байгаа нь сумын хэмжээний нийт газрын дөнгөж 0.27 хувь




болно. Үүнээс 3921.61 га нь хот суурингийн тэг гортигт хамаардаг байна. Сумын хот, суурин газрын 64.0 хувийг нь уурхайн зориулалттай газар эзэлж хот, тосгон, суурин газрын дөнгөж 1 хувийг барилга, 0.5 хувийг цэцэрлэгт хүрээлэн, зам гудамж талбай бүхий нийтийн эзэмшлийн газар эзэлж байна.

Хүн ам, хөдөлмөр эрхлэлт

Сумын нийт хүн ам, өрхийн тоо. Гурвантэс сумын хүн ам 2017 оны жилийн эцсээр 4799 хүнээр тоологдож байснаасаа хойш жил бүр 38-108 хүнээр өсөж ирсэн 2022оны жилийн эцсийн дүнгээр 5300 байсан нь өмнөх оноосоо 38 хүнээр олон болсон байна.

Харин 2022 онд 5300 хүн бүртгэгдсэн нь 2021 оныхоос 38 хүнээр нэмэгдсэн байна. Сумын нийт амын 22.0 хувь Тост багт, 19.0 хувь нь Гоёот багт, 29.0 хувь нь Урт багт, 11.0 хувь нь Бага-Овоо, 19.0 хувь нь Баясах багт тус тус бүртгэлтэй байна.



Зураг 24. Гурвантэс сумын хүн амын өсөлтийн динамик ба хуваарилалт, 2018-2022

Сумын өрхийн тоо 2017 онд 1527 байснаа 2022 онд 1765 болтлоо өссөн бөгөөд түүний тооны өсөлт нь хүн амын тооны өөрчлөлттэй адил төлөвтэй байгаа юм. Нэг өрхөд ногдох гишүүний тоо сумын хэмжээнд дунджаар 3 байгаа нь аймгийн сүүлийн жилүүдийн дунжийн хэмжээнд байгаа ч өсөлтийн олон жилийн дундаж нь 4.3 байна.

Хүснэгт 19. Гурвантэс сумын хүн ам болон өрхийн тоо, тэдгээрийн өөрчлөлт. 2017-2022

Он	Хүн ам	Хүн амын жилийн өсөлт	Өрх	Өрхийн жилийн өсөлт
2017	4869	140	1527	40
2018	5141	272	1558	31
2019	5101	40	1567	9
2020	5207	106	1648	81
2021	5316	109	1717	69
2022	5283	-30	1765	48
Дундаж өсөлт		106.1		46.3

ОН

Хүн амын шилжилт хөдөлгөөн. Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн, хүүхдэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон НҮБ-ын Хүүхдийн сангийн судалгаанаас үзэхэд



тус суманд бүртгэлтэй 16 мянган хүн түр оршин суудаг байна. Мөн орон нутгийн төрийн байгууллагын мэргэжилтний мэдээлснээс үзэхэд бүртгэлтэй 20 гаруй мянган хүн ажиллаж, амьдарч байна.

Харуулснаар дундаж өсөлтийн өрхөд эзлэх хүн амын тоо 4.3 байгаа нь шилжин ирж буй өрх, хүн амын тооны зохист харьцааны төвшин улсын дунджаас 0.6 пунктээр өндөр

буюу ганц бие шилжин ирж буй хүмүүс зонхилж байгааг харуулна. Хүн амын шилжилт суурьшилтыг тооцохдоо дан ганц механик өсөлтийн /шилжин ирэлт ба явалтын зөрүү/ зэрэгцээ өсөлтийн дунжийг тооцож, нийт хүн амын өсөлтийн дунжийг өрхийн өсөлтийн дундаж үзүүлэлттэй харьцуулсан нь энэхүү дүгнэлт хийх нөхцөл байгаа юм.

Гурвантэс сумын төв рүү буюу шилжин ирэгсдийн урсгалыг авч үзэхэд 9 хувь нь өөрийн сумын бусад багаас, мөн 9 хувь нь Өмнөговь аймгийн өөр сумдаас, мөн 9 хувь нь

өөр аймгаас шилжин ирсэн байдаг ба Өмнөговь аймгийн төв болон Улаанбаатар хотоос шилжин ирэгсэд маш бага байна. Харин 73 хувь нь бусад газраас гэдэг нь угтаа Дархан, Эрдэнэт хотуудаас шилжин ирсэн хэрэг болно.


Хүн амын хөдөлмөр эрхлэлт.

2022 оны эхний 10-р сарын байдлаар сумын хөдөлмөрийн захад бүртгэлтэй ажил хайж байгаа 7 иргэн байгаа бөгөөд өмнөх оны үетэй харьцуулахад 2 хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Тайлант сард шинээр бүртгүүлж, бүртгэлээс хасагдаж, ажилд орсон иргэн байхгүй байна.

Хүснэгт 20. Гурвантэс сумын ажил хайгчдын хөдөлгөөн, жишээ болгосон 2022 оны 10 сараар

Илэрхийлэл	Бүртгэлтэй ажилгүйчүүд		Тайлант сардаа			Үүнээс: Боловсролын төвшингээр							
	Сарын эхэнд	Сарын эцэст	Нэмэгдсэн	хасагдсан	Ажилд орсон	Боловсролгүй	Бага	суурь	Бүрэн дунд	Мэргэжлийн	Тусгай дунд	Дээд	Магистр, доктор
Хүн	9	7	0	0	0	0	0	1	1	2	2	1	0

Сумын хэмжээнд ажил эрхлэгчдийн 91.5 хувь нь байнгын, 7.0 хувь нь улирлын чанартай,



1.5 хувь нь түр буюу нэг удаагийн ажил эрхэлж байна. Ажил хайгсдын цөөнх нь суурь, бүрэн дунд боловсролтой иргэд байсан бөгөөд дээд боловсролтой ажил хайгсад 1 бүртгэгдснээс гадна тусгай дунд боловсролтой 2 хүн, мэргэжлийн боловсролтой 2 хүн байсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн гол талбар нь МАА-н салбар давамгайлж ирсэн ба малчин өрхийн тоо 2014 оноос хойш байнга өссөөр ирсэн төдийгүй сумын нийт өрхөд малчин өрхүүдийн эзлэх хувийн жин 2018-2022 онд 0.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 21. Гурвантэс сумын малчин өрх, нийт өрхөд эзлэх хувийн жин, 2018-2022 он

Үзүүлэлт	Жилүүдээр				
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Малчин өрх	637	620	685	666	649
Нийт өрхөд эзлэх хувь	42.8	39.5	41.5	38.7	36.7

Сумын дэд бүтэц

Ус хангамж: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын “Шугшаа уул” ОНӨААТҮГ-ын ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөлтэй ажилладаг.

Сумын төвд ус хангамж, ариутгал татуургын системийг Өмнөговь, Дорноговь аймгийн хилийн ойролцоох суурин газруудын хөгжлийн GO204-MON төслийн хүрээнд

2015 онд ашиглалтад оруулсан. Тус систем нь сумын төвийн орон сууц, үйлдвэр ААНБ-ууд, айл өрхүүдэд үйлчилгээ үзүүлдэг цэвэр усны эх үүсвэрийн гүний 2 худагтай.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс 2017 оны 1 дүгээр сарын 09-ны өдөр 07 тогтоол гаргаж Өмнөговь аймгийн Гурвантэс сумын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф баталсан. Үүнд:

- Сумын үйлдвэр ААНБ-ын цэвэр усны үйлчилгээ 4.0-6.0 төг/л, бохир усны үйлчилгээ 4.0-12.0 төг/л,
- Хүн амын цэвэр болон бохир усны үйлчилгээ 1.82/төг/л,
- Усны үйлчилгээний тогтмол тариф нь айл өрхөд 1000 төг/сар, үйлдвэр ААНБ-д оролтын шугамын голчоос хамааран 2.8-20.8 мян.төг/сар байна.

Цаашид үйлдвэрлэл болон хүн амын өсөн нэмэгдэж байгаа нөхцөлд ус хангамжийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

Автозам: Өмнөговь: “Нутгийн хишиг” хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд иргэд олон нийтийн санал санаачилгад үндэслэн бүтээн байгуулсан "Нутгийн зам" төсөл нь Өмнөговь аймгийн баруун бүсийн сумдыг автозамаар холбох зорилготой Даланзадгад-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг анх 2013 онд эхлүүлж байсан бөгөөд 2022 он хүртэл нийт 144 км замыг барьж байгуулан ашиглалтад оруулсан.

Эрчим хүч: Өмнөговь аймгийн Ноён, Гурвантэс, Сэврэй сумд БНХАУ-ын ӨМӨЗО-ны ЧИНХУА группээс тог цахилгаанаар хангагддаг.

Харилцаа холбоо: Тус бүс нутагт “Монголын цахилгаан холбоо” компанийн суурин утасны системээс гадна хөдөлгөөнт холбооны 4 оператор компанийн сүлжээ нэвтэрсэн нь сумын төв болон уурхайн орчинд саадгүй ажиллана. Сум интернэт холболттой бөгөөд “Монгол шуудан”-гийн салбар ажилладаг. Тухайлбал:

•Монголын цахилгааны холбооны үйлчилгээг компанийн харьяа Өмнөговь аймгийн холбооны газраар дамжуулан авдаг. “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн Засаг даргын хүсэлт, ҮДТ УТҮГ-ын техникийн дүгнэлтийг үндэслэн тус аймгийн Гурвантэс сумын орон нутгийн хөрөнгөөр худалдан авсан цахим машиныг Төрийн үйлчилгээний цахим машины системд холбох зөвшөөрлийг олгосон. Мөн Автотээврийн үндэсний төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу тус төвд ТҮЦ машиныг шилжүүлэн байршуулах зөвшөөрлийг олгосон.

•Мобикомын үүрэн операторын сүлжээний хүрээнд гар утасны борлуулалт, засвар үйлчилгээ, “Цахим сургалт” төслийн хүрээнд сумын сургуулиудад цахим удирдлага хяналт, сургалтын программ нэвтрүүлж, портал цахим хуудастай болгож, өндөр үзүүлэлт бүхий суурин болон зөөврийн компьютер, дижитал проектороор тоноглогдсон интернэтийн өндөр хурдтай иж бүрэн танхимыг байгуулсан.дамжуулан хүргэх ангиллын (Юнителийн сүлжээгээр дамжуулах) зөвшөөрөлтэй байна.

Дулаан хангамж: Сумын 4-р багт байршилтай “Хөгшөө” ОНӨААТҮ газар нь аж ахуй нэгжид цахилгаан түгээж, төсвийн болон аж ахуй нэгжид дулааны хэрэгцээг хангадаг.

Сумын эдийн засгийн үзүүлэлт

Сумын төсөв:Орон нутгийн орлогын гүйцэтгэл сумын хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар 7,167,243.0 төг хүрсэн нь 100 хувийн гүйцэтгэлтэй байсан орлого бүрдүүлэлтээр аймагтаа 10-т жагсаж байна


Хөдөө аж ахуй.

Мал аж ахуй. Сумын хэмжээнд МАА-н үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд нийт малын тоо, толгой 2022 онд 2016 оныхоос 1.04 дахин багассан байна. 2022 оны байдлаар нийт мал сүргийн 86.3 хувийг ямаан сүрэг, 6.5 хувийг хонин сүрэг эзэлж, 7.2 хувийг бодын сүрэг эзэлж байна. Нийт сүрэг үхэр болон адуу хамгийн бага хувийн жинтэй байна.

Хүснэгт 22. Гурвантэс сумын малын боо, нийт толгой болон төрлөөр, 2016-2022 он

Мал, малын төрөл	2016	2017	2018	2019	2020	2021	2022		
							толгой	Хувь, %	
Нийт мал	181.56	205.08	187.46	225.9	237.71	177.1	173.6	100	
Үүнээс:	Адуу	3.21	3.85	3.55	4.18	4.04	3.2	3.32	1.9
	Үхэр	0.39	0.47	0.45	0.57	0.61	0.56	0.59	0.3
	Тэмээ	7.38	7.84	8.06	8.33	9.37	9.07	8.57	5
	Хонь	10.51	11.5	10	11.68	12.56	10.59	11.29	6.5
	Ямаа	160.07	181.42	165.41	200.53	211.13	153.68	149.85	86.3

Сумын нийт малын 33.0 хувь нь Гоёот багт, 27.0 хувь нь Баясах багт, 27.0 хувь нь Тост багт, 3.0 хувь нь Урт багт, 10.0 хувь нь Бага-Овоо багт хамаардаг байна.



Зураг 25. Гурвантэс сумын малын байришил болон багууд дахь нийт малын тооны өөрчлөлт

Газар тариалан. Сумын хэмжээгээр 2022 онд нийт 32.4 га талбайд тариалалт хийж байгаагаас 4 га талбайд төмс, 5.5 га талбайд хүнсний ногоо, 8.7 га талбайд тэжээлийн ургамал, 8.7 га талбайд ногоон тэжээл тариалсан байна.

Сумын хэмжээнд байцаа, лууван, шар манжин, сонгино, саримс зэрэг өргөн хэрэглээний ногооноос гадна өргөс хэмх, улаан лооль, тарvas, амтат гуа, чинжүү зэрэг нарийн ногоо тарьж хураажээ.

Сумын нийгмийн байдал

Орон нутгийн удирдлагын үйлчилгээ



ЗДТГ-ын байр нь 2018 онд ашиглалтад орсон тоосгон хийцтэй, зориулалтын барилга бөгөөд инженерийн байгууламжид холбогдсон байна. Сумын ЗДТГ-т нийт 15 ажилчинтай сумын ард иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Гурвантэс сум нь Засаг захиргааны 5 нэгжид хуваагддаг.



Зураг 26. Гурвантэс сумын цахим орчин дахь мэдээллийн сайт болон facebook –ийн харагдах байдал /2023.11.01/

Сумын эрх зүйн байдал. Сум бол Үндсэн хуулийн үзэл баримтлал ёсоор нутгийн өөрөө удирдлагын гол цөм, хүн амыг өдөр тутмын наад захын нийтийн үйлчилгээгээр шууд хангаж байх үндсэн үүрэгтэй, Монгол Улсын тулгуур нэгж юм. Тулгуур нэгжийн хувьд Гурвантэс сумын эрх зүйн байдлыг дараах нөхцөлөөр тодорхойлж байна. Үүнд:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нийгэмшлийн бүрдүүлбэр болох хүн ам-нийгэмшил нь амьдралын орчин, төрийн болон зах зээлийн үйлчилгээний хүртээмж, чанараас шалтгаалдаг. Хүмүүс 1) амьдрах нөхцөл хүнд, 2) ажлын байргүй, эсвэл орлого бага, 3) төрийн болон бизнесийн үйлчилгээ чанаргүй зэрэг “гурван муу” зэрэгцсэн орчноос дайжин шилждэг бол Гурвантэс сумын хувьд түүн рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн сүүлийн 10-аад жилийн турш үргэлжилж байгаа юм.

- Зарим судлаачдын тооцоолсноор сумын хүн ам 5000 хүрч байж нийгэм, эдийн засгийн цогцолбор болж чадна гэж үздэг. Монгол улсын хэмжээнд 7500-аас олон хүн амтай 32 сум байгаа бөгөөд тэдгээрийн 1 нь Гурвантэс сум байна. Эдгээр сумдад хүн амын өсөлт нь 1.2 хувиас их байгаа ба сумын төвд байх хүүхдийн сургууль цэцэрлэгт хамрагдах төвшин нь 90.0-ээс дээш хувьтай болж чадсан байгаа юм. Энэ нь нийгэм, эдийн засгийн хувьд бие даах, хүн амын анхдагч хэрэгцээний үйлчилгээг үзүүлэх хэмжээний хөгжилтэй, хүн ам нь тогтвортой аж төрөх зохистой тооны хүн ам бүрдсэн сум болохыг харуулж байна.

- Зах зээлийн хуулиар бол хүн амын нягтрал талаас нэг ам км газар нутагт 10 хүн суурьшиж байж тэнд зах зээл үүсдэг байна. Энэ нь дор хаяж талх барьж зарахад ашигтай байх нөхцөл бөгөөд Гурвантэс сум нь сүүлийн 5 жилд хүн амын нягтшилаар 0.8-1.1 хүн/км²

үзүүлэлттэй байгаа нь улсын дунджаас 1.0-1.1-ээр бага, Өмнөговь аймгийн дунджаас 0.49-0.70-оор их байна.

Сумын чиг үүрэг. Сумдын удирдлага өдөр тутмын үйл ажиллагаа хуулийн хүрээнд хэрэгжүүлж байгаа ч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг нэгжийнх нь хувьд тусгайлан заагаагүй тул сумын эрх зүйн байдал гэхээсээ илүү сумын удирдлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон нөхцөл ноёлж байгаа юм. Төсвийн тухай хуулиар анх удаа аймаг, нийслэл, сум, дүүргийн чиг үүргийг Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу хуваарилах оролдлого хийгдсэн ч нөхцөл байдал дараах ээдрээтэй төлөвтэй байна. Тухайлбал:

•Сум нь хүн амд ойр, төрийн үйлчилгээг хүргэх үүрэгтэй засаг захиргаа нутаг, дэвсгэрийн суурь нэгж байтал ард иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний суманд байхаар чиг үүргүүд нь аймагт хуваарилсан зохицуулалттайгаас сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын үйлчилгээ сумын удирдлагад хамааралгүй болсон байна. Тиймээс Гурвантэс сумын эмнэлгийн зардал хүрэлцээгүй, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн тоо хүчин чадлаасаа хэтэрсэн ачаалалтайгаар олон жил болсон байдаг. Сумын сургууль гэхэд хүүхэд нь сумынх, хөрөнгө нь аймгийнх, төсөвт сайдын багцад байна.

Эрүүл мэндийн үйлчилгээ.

Суманд 15 ортой 1 эмнэлэг, 1 эмийн сан үйл ажиллагаа явуулж, 4 их эмч, 10 эмнэлгийн тусгай мэргэжилтэн ажиллаж байна. 2022 оны эхний 10 сарын байдлаар 76 эх амаржиж 27 хүн нас барсалт тэмдэглэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 47.1 хувиар бага байна.

Сумын нэр	Төрөлт		2022/2021	Нас баралт		2022/2021
	2021.Х	2022.Х		2021.Х	2022.Х	
Гурвантэс	80	76	95.0	19	27	142.1

Хүснэгт 23. Сумын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гол онцлогууд, 2022 он

№	Үзүүлэлт	Тоон үзүүлэлт
1	Сумын эмнэлэг	1
2	Эмч	4
3	Сувилагч	5
4	Эх баригч	2
5	Бусад ажилчид	10
6	Нийт ажилчид	22
7	Машин	1
8	Эмнэлгийн ор	22
9	Хүн ам	5283
10	Нэг эмчид ноогдох хүний тоо	1116
11	Нэг сувилагчид ноогдох хүний тоо	893
12	Нэг орон ноогдох хүний тоо	183
13	Нэг эмчид ноогдох хүний тоо, хувиар	-153%
14	Нэг сувилагчид ноогдох хүний тоо, хувиар	-136%

№	Үзүүлэлт	Тоон үзүүлэлт
15	Нэг орон ноогдох хүний тоо, хувиар	-41%



Эрүүл мэндийн төвийн барилга. Сумдын их эмч сувилагчдын тоо ба ачаала нь ерөнхийдөө уг суманд 4 их эмчтэй нэг эмчид ногдох хүний тоо 1116 сувилагчийн тоо 5 нэг сувилагчид ногдох хүний тоо 893 эмнэлгийн хүний тоо 10 стационарт эмчлэгдсэн 419 хүн байна гэж бүртгэгджээ. үйлчлэхээр болж байна.

Сумын иргэдийн эрүүл мэндийн байдал. Уурхайн нөлөөллийн бүсийн хүн амын нас баралтын гол шалтгаанд зүх судалсны өвчин, хоол боловсруулах замын эмгэг, хорт хавдар, амьсгалын замын өвчин, бэртэл гэмтэл, хордлого, бусад гаднын шалтгаан орж байна. Сумын хэмжээнд нас баралт жилүүдээр буурч байгаа таатай үзэгдэл байгаа ч энэ нь өвчтөн сумын эрүүл мэндийн үйлчилгээг хангалтгүй гэж үзэх үедээ аймаг, нийслэл рүү явдагтай холбоотой байж болно.

2017-2022 онд бүтгэгдсэн нас баралтын дийлэнх нь янз бүрийн өвчнөөс үүдэлтэй байна. Гэхдээ амиа хорлолт, авто машины осол нас баралтын хоёрдогч шалтгаан болсон байна.

Сумын нийт өвчлөлийг авч үзвэл амьсгалын тогтолцооны өвчлөл сүүлийн жилүүдэд өсөж байна.

Боловсролын үйлчилгээ

Боловсролын гол үйлчилгээ. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн ачаалал харьцангуй өндөртэй сумдын тоонд Гурвантэс сум ордог бөгөөд 1 үндсэн багшид ногдох сурагчдын тоо нь 22 байгаа нь аймгийн дунджаас 4 сурагчаар илүү байна Харин Ханхонгор, Ноён, Сэрвэй, Хүрмэн сумдад ерөнхий боловсролын сургуулийн багшийн ачаалал бага байна. Сургуулийн өмнөх боловсролын үндсэн багшийн ачаалал дунджаар 1 багшид 40 сурагч ногдов. 2021-2022 оны хичээлийн жилд гурвантэс сум нь нийт 58 үндсэн багштай үүнээс сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш 9 ерөнхий боловсролын сургуулийн багш 49 байх ба 1 багшид 17 сурагч тус тус ногдож байгаа үзүүлэлттэй байна.



Зураг 27. Гурвантэс сум дахь гадаад хэлний сургууль

Боловсролын үйлчилгээний барилга байгууламж. Сумын хэмжээнд ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 2, цэцэрлэгийн 2, соёлын төв 2, номын сангийн 1 барилга ард иргэдэд соёл, боловсролын үйлчилгээ үзүүлэх зориулалттайгаар ашиглагддаг байна.

Хүснэгт 24. Гурвантэс сумын соёл, боловсролын байгууламжууд


№	Үйлчилгээний зориулалт	Байршил	Хүчин чадал	Одоогийн ашиглалт	Ашиглалтад орсон он	Инженерийн холболт
1	ЕБ-ын сургууль	Урт баг	400 хүүхэд/жил	1000 орчим хүүхэд жил	1969	Бие даасан шийдэлгүй
2	ЕБС-ын сургууль	Урт баг	320 хүүхэд/жил	700 гаруй хүүхэд/жил	2013	Инженерийн шугамд холбогдсон
3	Сургуулийн хүүхдүүдийн дотуур байр	Урт баг	250 хүүхэд/жил	150 гаруй хүүхэд/жил		



Зураг 28. Сумын ЕБС-ын болон цэцэрлэгийн 2019, 1975 оны барилгууд

Хүн амын амьжиргааны байдал

Гурвантэс сумын хувьд өрхийн дундаж орлогын үзүүлэлтээр бүс нутагтаа дээгүүрт орно. Энэ нь тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудтай холбоотой бөгөөд цалингаас хамаарч тус салбарт хөдөлмөр эрхлэх хандлага эрс нэмэгдсэн байна. Ядуурлын төвшин улсын хэмжээнд 29.6 хувиар үнэлэгдсэн байхад Өмнөговь аймагт 15.4 хувь, Гурвантэс суманд 12.9 хувьтай байна.



Уурхайд ажиллагсдын дундаж цалин 986.0 мянган төгрөг/сар, тээвэр болон агуулахын үйл ажиллагааны дундаж цалин 879.0 мян.төг/сар байгаа нь Цогтцэций сумын өрхийн дундаж орлогод нөлөөлнө гэж бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн 2018 оны судалгаагаар тогтоосон байна. Сумын хэмжээнд өрхүүдийн орлогын 63 хувь нь цалин хөдөлмөрийн хөлс байх

бөгөөд бизнесийн орлого 11 хувийг эзэлж байна. Тэтгэвэр болон тэтгэмжийн орлого тус бүр 6, 6 хувийг эзэлж байгаа нь бага биш юм.

Зөвхөн цалингийн орлоготой өрхүүдийн дийлэнх нь төрийн байгууллагад ажилладаг гишүүнтэй байдаг хэдий ч Гурвантэс суманд иргэдийн 18.1 хувь нь гадаад болон дотоодын хөрөнгө оруулалттай компанид ажиллаж, 33.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна.

Мөн хуримтлагдах нөлөөллийн судалгаанд оролцогчдын 62.5 хувь нь амьжиргааны байдлаа өмнөх үеийнхээс дээшилсэн гэж хариулсан нь бүс нутгийн бусад сумдынхаас бараг 2 дахин их байжээ.

Бага-Овоо баг:

Бага-овоо баг нь 2018 оны 11-р сарын 29-ний өдөр шинээр байгуулагдсан. Багийн анхны даргаар Нямын Түвшин сонгогдон ажиллаж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар 210 өрхтэй 631 хүн амтай, 22193 толгой малтай, эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй, газар тариалан, Мөн Нарийн сухайтын нүүрсний бүлэг ордын сайн чанарын чулуун нүүрс, метан хий баялагийн олборлот, экспорт юм.

Бага-Овоо баг нь 276264.5776 га нутаг дэвсрэгтэй нутаг дэвсгэр баруун, баруун урд талаараа Тост баг, хойд талаараа Урт баг, зүүн, зүүн хойт талаараа Баясах баг, өмнөд хэсгээрээ БНХАУ-ын ШУӨЗО-ны Альша аймгийн Эзний хошуутай зах нийлэн хиллэдэг. Монгол-Алтайн нурууны цөлөрхөг бүсэд оршдог. байгалийн үзэсгэлэнт газар ихтэй, Хөгшөө, Шугшаа, Суварга, Товон, Буурал, Их бага Баян, Сүмбэн, Тахилгат, Хайлаастын өндөр уулс, Хайлаастын хөндий, Шатын ам, Хуршуутын гол, Зүүн, баруун сухантын гол горхиуд нь Жигэд, Хайлаас, Тоорой, Заган ой бүхий баян бүрдүүдтэй. Баянгийн болон Хайрт рашаан уснаас гадна хармаг, лидэр, чихэр өвс улаан, цагаан гоёо, таван салаа, хурдан цагаан, бажууна, эмт өвс зэрэг эмийн ургамлууд ургадаг. Аргаль, янгир хар сүүлт ирвэс, чоно, мануул, үнэг, шилүүс, зэрэг ан амьтад, олон төрлийн жигүүртэн шувууд амьдардаг. Цаашид аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой газар нутагтай. Үүнээс сумын Есөн гайхамшигт Хайлаастын хөндий багтдаг.

Бага-Овоо багаас төрсөн гарсан алдартнууднаас: Улсын аварга малчин Цэрэндондогийн Осор, Улсын аварга ногоочин С.Даш, БНМАУ-ын Улсын залуу аварга малчин О.Цогзолмаа, Аймгийн аварга малчин Д.Мөнхөө, Аймгийн аварга ногоочин С.Даш, Д.Нямсүрэн, Б.Амарбаясгалан, ХХААХҮ-н тэргүүний ажилтан Д.Цэндээхүү, Худалдааны тэргүүний ажилтан С.Намжилцэрэн, Боловсролын тэргүүний ажилтан Ц.Уранмандах, Эмнэг хангал сургалтын спортын мастер О.Дарханбаатар нарын зэрэг олон алдар цуутнуудтай.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь барилга байгууламж барих овоолго үүсгэх зэрэг ажлыг гүйцэтгэхэд 9.8 га талбай хөндөгдөж нөлөөлөлд өртөхөөр байна.

3.1. Төслийн болзошгүй нөлөөлөл

Төслөөс байгаль орчны бүрэлдэхүүнд тус бүрт үзүүлж болзошгүй нөлөөлөл

№	Ү зүүлэлт	Нөлөөллийн түвшин	Тайлбар
1	Газрын хэвлий рельеф	Их	Ажлын үед шинээр хөрс хуулах, уурхайлалтын ажил хийгдэх тул энэ төрлийн нөлөөлөл их гэж үзлээ. Нийт 1.7 га талбайд 40метр гүнтэй ухлага үүснэ
2	Цаг уур, уур амьсгал	Дунд	Цаг агаарын нөхцөл байдал төслийн үйл ажиллагаатай шууд хамааралтай байдаг бөгөөд цаг уурын таагүй /үер, салхи/ байдлаас төслийн ажил зогсох, удаашрах зэргээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хугацаа уртасна. Хүчтэй салхи, шороон шуургаар ил задгай барилгын болон ажилчдын хог хаягдал хийсч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлж болзошгүй.
3	Агаарын чанар	Бага	Төслийн үйл ажиллагаа, техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөний үйл ажиллагаанаас тоос шороо үүснэ. Төслийн талбайд ажиллах техникүүдийн түлшний шаталтаас хүлэмжийн хий ялгарна.
4	Усан орчин	Бага	Төслийн талбайн нөлөөллийн бүсэд гадаргын уст цэг байхгүй тул нөлөөлөл үзүүлэхгүй, гүний усны түвшинд төслийн ажил явагдахгүй учраас нөлөөлөхгүй.
5	Хөрс, газрын гадарга	Их	Төслийн үед хөрс хуулалт, газар шорооны ажил барилгажих талбайн хэмжээгээр хийгдэх тул энд үзүүлэх нөлөөллийг их зэрэг гэж үзсэн.
6	Ургамал	Их	Төслийн ажил явагдах талбай нь барилгажаагүй, техноген нөлөөлөлд өртөөгүй талбай байна. Уг талбай нөлөөлөлд өртөх тул энэ нөлөөллийн эрчим их байна.
7	Амьтан	Дунд	Төслийн талбай нь суурин газар учир хүн болон техникийн хөдөлгөөн, дуу чимээ ихтэй тул мэрэгч амьтад болон бор шувууны багийн жижиг шувууд болон синнантроп зүйлүүдээс бусад амьтад ерөнхийдөө шилжилт хөдөлгөөн хийнэ. Тос тосолгооны асгаралтын үед дутуу цэвэрлэхэд
8	Дуу чимээ, доргилт, чичиргээ	Бага	Төслийн ашиглалтын үед, ачих, тээвэрлэлт тэсэлгээ зэргээс үүсэх дуу чимээ, чичиргээ нь ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
9	Үнэр	Дунд	Ажлын байрны орчин нь агаарын бохирдолтой тоосжилтой бүс тул ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл дунд.

Төслийн үйл ажиллагаатай холбогдуулан байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлийн хэсгүүдтэй уялдуулан авч тодорхойлбол:

Хүснэгт 25. Төслийн үйл ажиллагааны үед байгаль орчинд үзүүлэх бохирдол, нөлөөллийн эх үүсвэр, шинж чанар, өртөгдлийн байдал

№	Бохирдол, нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
1	2	3	4
Нэг. Орчин			
1.1	Тоосжилт	Уурхайлалт, тэсэлгээ, тээвэрлэлт	• Төслийн талбай орчим тархах, ажилчдын эрүүл мэндийн байдалд нөлөөлнө
1.2	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, угаар	Тээвэрлэлтэнд хэрэглэгдэх машин, механизм	- Агаар орчинд тархах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
Хоёр. Усан орчин			
2.1	Хатуу болон шингэн хог хаягдал	Ахуйн болон шатах тослох материалын хаягдал Тээвэрлэлтийн явцад техникийн бүрэн бус байдал, хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас	- Хур борооны усаар угаагдаж хөрс, гүний ус бохирдуулна
Гурав. Хөрс			
3.1	Эвдрэл	Байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс эвдрэл, элэгдэлд өртөгдөх, талхлагдах	- Хөрсний физик механик шинж чанарт өөрчлөлт орж болно. -Үйл ажиллагааны хяналтаар нөлөөллийг бууруулах боломжтой.
3.2	Бохирдол	Шатах тослох материалын болон ахуйн хог хаягдлын асгаралт, болгоомжгүй байдлаас болзошгүй нөлөөлөл үүснэ.	- Хэмжээ хязгаарлагдмал Хөрс бохирдноос хөрсний шинж чанар, микробиологийн шинж чанарт өөрчлөлт орж болно - - бохирдлоос сэргийлэх, бохирдох замыг хаалттай байлгах боломжтой.
Дөрөв. Ургамал бүрхэвч			
4.1	Газар шорооны ажлын үед	Ургамлан бүрхэвч бүхэлдээ устгагдах, дарагдах байдлаар үгүй болно.	- Хэмжээ хязгаарлагдмал -Төрөл, зүйл устаж, өөрчлөгдөж болно
4.2	Талхлагдах	Техникийн хөдөлгөөнөөр үйл ажиллагаанд байнга өртөж буй зам, талбай, ашиглалтын объектуудын орчин	- Биомассын хэмжээ багасна - Төрөл зүйл устаж болно Нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно.
Тав. Нийгэм эдийн засгийн орчин			
6.1	Шинээр ажиллагсад авна	Эдийн засгийн чадавч дээшилнэ. Ажлын байр шинээр бий болно	- төсөл хэрэгжих хугацаанд

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдал, экологи, орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар хийсэн.

Судалгаанаас үзэхэд тус энэхүү төслийн үйл ажиллагаа нь байгаль орчинд шууд ба шууд бус нөлөөллийн давхардсан байдлаар 22 нэр төрлийн нөлөөлөл үзүүлж болзошгүй байна. Эдгээрээс улсын хэмжээнд нийгэм, эдийн засгийн чиглэлээр үзүүлж буй эерэг нөлөөлөл 6 байгаа бөгөөд үлдэх 18 хэлбэр нь сөрөг нөлөөлөлд хамаарна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг магадлан жагсаалтанд оруулан тэдгээрийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, нөлөөллийн байдал зэргийг нэгтгэн тодорхойлсноор ерөнхий дүр төрхийг харж болох юм. Мөн нөлөөллийн байдлыг дор дурьдсанаар авч үзэж болохоор байна.

Хүснэгт 26. Болзошгүй нөлөөллийн магадлан жагсаалт

Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөлөл			Хугац		Давта		Эрчим		
	Шууд	Шуудбус	Өөрөө зохицуулагдах	Богно хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хугцгэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		X			X					X
Ургамлын бүтцийн өөрчлөлт										
Хөрсний элэгдэл, эвдрэл	X				X		X		X	
Геологийн тогтоцын өөрчлөлт										
Зэрлэг амьтдын орон зай										
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		X								X
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал										
Эрдэс түүхий эдийн нөөц										
Эрчим хүчний нөөц		X			X					X
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	X				X		X			X
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	X			X						X
Хөрсний эвдрэл, бохирдол		X			X				X	
Нефт бүтээгдэхүүнд агуулагдах хүнд металл хөрс, усаар дамжин хүнд нөлөөлөх		X			X				X	
Дуу чимээ, шуугианы нөлөө, чичиргээ	X			X						X
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, Палентологийн олдвор										

Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх										
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх										
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			X	X		X				X
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх		X			X		X		X	
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		X			X		X	X		
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		X		X					X	
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	X			X					X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		X		X						X
6. Эдний засаг, байгаль орчин										
Татварын орлого өөрчлөгдөх	X			X					X	
Орон нутгийн орлого нэмэгдэх	X			X					X	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	X			X					X	
Ажлын байр нэмэгдэх	X			X						X
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X			X		X			X	
7. Бусад нөлөөлөл										
Зам харилцаа, тээврийн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх		X					X			X
Ахуйн бохир уснаас хөрс ба грунтын усыг бохирдох		X			X				X	
Бодисын алдагдлаар хөрс бохирдох		X			X				X	
Химийн бодис, аюултай хог хаягдалтай холбогдох аюулгүй ажиллагаа, холбогдох эрх зүйг хангаагүй үед	X				X		X	X		
Дүн	1	1	-	1	1	2	6	2	1	1

Шууд нөлөөлөлд болзошгүй нөлөөллийн 11 нь хамрагдаж байна. Энд хамгийн гол нөлөөлөл нь төслийн үйл ажиллагаа эхлэхэд тухайн талбайд өртөгдөх хөрс, ургамалд үзүүлэх нөлөөлөл байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаа эрхэлснээр орлого өсөх, хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх, орон нутгийн орлого болон ажлын байр нэмэгдэх зэрэгт эергээр, харин агуулахын ажлын байрны нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих нөхцөл бүрдэх, химийн бодис, аюултай хог хаягдалтай холбогдох аюулгүй ажиллагаа, холбогдох эрх зүйг зөрчих зэрэг нь сөргөөр тус тус нөлөөлөхөөр байна

Шууд бус нөлөөлөлд тос тосолгооны материал, түлш бохир усны болзошгүй алдагдал нь хөрсөнд нэвчиж хөрс болон газрын доорх усыг бохирдуулан хүн амьтанд нөлөөлөх, газрын доорх усны нөөц, чанар болон хөрсний элэгдэл, бохирдол бий болох, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зөрчлүүд нь ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварт нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөлөл хамаарч байна. Мөн ядуурлыг бууруулахад эергээр шууд бус нөлөөлөхөөр байна.

Богино хугацааны нөлөөлөлд ажлын байрны нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх,

ахуйн болон хог хаягдлыг шаардлагын дагуу хадгалах, зайлуулах арга хэмжээг төлөвлөөгүйгээс, хогийн цэгийн битүүмжлэл, ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих зэрэг нь богино хугацааны нөлөөлөлд хамаарч байна.

Урт хугацааны нөлөөлөлд дээр авч үзсэн нийт 11 нь хамрагдаж байна. Гэхдээ эдгээрээс газрын доорх усны чанар, урсцын өөрчлөлт, төслийн талбай орчны хөрсний элэгдэл, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл зэрэг нь сөрөг нөлөөлөлд хамаарч байхад дэд бүтэц, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа, хүн амын орлого өөрчлөгдөх, орон нутгийн орлого нэмэгдэхэд урт хугацаанд эерэг нөлөөлөхөөр байна.

Иймээс газрын доорх усыг ямар нэг байдлаар бохирдуулахгүй байх гол арга хэмжээ нь хөрсний бохирдлоос сэргийлэх арга хэмжээг үргэлж авч хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Нөлөөллийн давталт: байгаль орчинд нөлөөлөх урт хугацааны нөлөөллүүдээс газрын доорх усны урсац ба чанарын өөрчлөлт, орчны хөрсний элэгдэл, эрчим хүчний нөөц зэрэг сөрөг нөлөөлөл болон нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллүүдээс хүн амын орлогын өөрчлөлт, орон нутгийн төсөвт оруулах орлого нэмэгдэх зэрэг эерэг нөлөөллүүд нь буцалтгүй нөлөөлөлд хамаарагдахаар байна. Харин хөрсний бохирдол, ахуйн хаягдал, зэрэг нь буцаж ажиллагсадын эрүүл мэндэд буцаж нөлөөлөх магадлалтай юм.

Нөлөөллийн эрчим: нийт нөлөөллүүдээс 12 нь дунд эрчимтэй, харин татварын болон хүн амын ба орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэг эдийн засагт эерэгээр дунд зэрэг, харин асгаралт, хаягдал усаар хөрс, газрын доорх ус бохирдох, хогийн цэгийн ариутгал муугаас орчныг бохирдуулах зэрэг нь дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Төслийн байршил, шийдэл, төлөвлөлттэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалтыг хийсэн. Объектын байршлын улмаас хүн ам, хүрээлэн буй орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллийг нийт 17 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 6 зүйлд нөлөөлөлгүй байна. Нөлөөллийн зэрэглэлээр үзэхэд 4 нь бага, 5 нь дунд ба 2 нь их нөлөөлөлтэй байна. Иймд төслийн байршил, шийдэл, төлөвлөлт холбогдсон болзошгүй нөлөөлөл бага харин болон хэрэгжүүлэхтэй төслийг хэрэгжүүлэх явцад тоосжилт үүсэх, тос тосолгоо, дизель түлш асгарах болзошгүй нөлөөлөл дунд байна.

Хүснэгт 27. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон
болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Их	Дунд	Бага
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Голын гольдролыг эвдэж, өөрчлөх, эрэг эвдрэн үерийн ус тавих нөхцөл бүрдэх	X			
Төслийн байршилтай холбогдож хүн амын нүүдэл бий болох, хүн амыг зөөж байршуулах шаардлага гарах	X			
Түүх, соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	X			
Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх.	X			
Голын усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх	X			
Төслийн байршил нь төмөр зам болон бусад барилга байгууламжинд харшлах эсэх	X			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, ус татах, хуваарилах болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой			X	
Болзошгүй осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг үер уснаас хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			X	
Технологийн үйл ажиллагааны үед ус, агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал болон их дуу чимээ гарах			X	
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх				X
3. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх				X
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			X	
Хөрсний эвдрэл элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)		X		
Шуурхай хяналтын үеийн хугацаа, санхүүгийн зардал тусгагдсан эсэх		X		
Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал			X	
4. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн үр дүн нь биологийн төрөл зүйлд осолтой, аюулд хүргэх		X		
Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжгүй болгох		X		

3.2. Төслийн гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь төслийн ашиглалтын үед тоосжилт, асгаралт үүсэх байна. Төслийн бүтээн байгуулалтын ажлын дараа нөхөн сэргээлт, орчны тохижилтын ажлыг хийсэн ч үйл ажиллагааны хяналт, хариуцлагаас хамаарч хөрсний эвдрэл, бохирдол, агаарын чанар, ажиллагсдын ажлын байрны орчин (гэрэлтүүлэг, чимээ шуугиан, чийгшилт, тоосжилт, мэргэжлээс шалтгаалах өвчлөл зэрэг) тоног төхөөрөмжийн засварын үйлчилгээнд ашиглагдах тос, тослох материалыг хөрсөнд асгаснаас үүдэх хөрсийг бохирдуулах бохирдол, бохир ус хөрсийг бохирдуулах, ахуйн хог хаягдал салхиар хийсэн орчныг бохирдуулах зэрэг асуудлууд нь сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой нөлөөллүүд байна.

3.2.1 Цаг агаарын хүчин зүйлсээс төслийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл

Байгалийн аюултай үзэгдлүүд болох хүчтэй салхи, шороон шуурга, бороо, үер зэрэг цаг агаарын хүчин зүйлсээс төслийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй. Манай Улсад цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 54 удаа тохиолддог байна. Сүүлийн 30 жилийн 3 арван жилд хувааж, 1 жилд тохиолдох цаг агаарын аюулт, гамшигт үзэгдлийн давтагдлыг дундажлан үзэхэд эхний 10 жилд дунджаар (1989-1998 он) 15 удаа, 2 дахь 10 жилд (1999-2008 он) 40 удаа, сүүлийн 10 жилд (2009-2018 он) 78 удаа тохиолдов. Тэдгээрээс уруйн үер 21%, салхи шуурга 21%, аянга цахилгаан 14%, нөөлөг салхи 10%-ийг эзэлж байна. Төслийн бүс нутагт 1993-2010 оны ажиглалтын мэдээнээс үзэхэд зуны улиралд нэг өдөрт (1996.08.10) 65.6 мм тунадас орсон нь тухайн жилд орсон нийт хур тунадасны 26%-ийг эзэлж байна. Энэхүү үзэгдэл нь дунджаар 15-20 жилд тохиолдох магадлалтай. Нэг хоногт ихээхэн хур тунадас орох нь өвлийн улиралд зуд болох, зуны улиралд хөрсний угаагдлыг нэмэгдүүлж үржил шимийг муутгахаас гадна байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн нэг болох үерийн нөлөөгөөр бэрхшээл, хохирол учруулдаг.

Салхины дундаж их хурд нь жилийн 4, 5 болон 9 дүгээр саруудад их, өвлийн сарууд болон 7, 8 дугаар саруудад бага байдаг. Салхины их хурд 1996 оны 4 дүгээр сард 28 м/с хүрч, богино хугацаанд салхины хурд огцом нэмэгдэж 40 м/с хүрч байсан.

Салхины ачаалал их болсон жилүүдэд гэр, хашаа унаж, байшингийн дээвэр цонх эвдэрч, холбоо, цахилгааны утас унах, мал сүрэг, хүний амь эрсдэх аюул бий болдог. Иймээс цаг агаарын эдгээр хүчин зүйлсийг барилга байгууламж барих, төлөвлөхөд тооцоолоогүйгээс эд материалын хохирол учирч болзошгүй. Иймд байгалийн эдгээр эрсдэлт үзэгдлүүдээс үзүүлэх ачааллыг тооцоолон байгуулах шаардлагатай болох нь харагдаж байна.

3.2.2 Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ

Монгол улсын агаарын тухай хуулинд зааснаар “Агаарын чанар” гэж агаарын чанарын стандартад нийцэж байгаа эсэхийг илэрхийлэх агаарын физик, хими, биологийн цогц шинж чанарыг хэлдэг. Энэхүү төслийн дараах үйл ажиллагаанаас агаарын чанарт нөлөөлөл үзүүлнэ. Үүнд:

- Хөдөлгөөнт тоног төхөөрөмж, машин техникийн ашиглалтын үед тоосжилт үүсэх, түүний хөдөлгүүрээс гарах хорт хий
- Дайрга шигших үед тоосжилт үүсэх

- Тэсэлгээний цооног өрөмдөх, тэсэлгээ хийхэд тоосжилт үүсэх
- Бутлуурын төхөөрөмж дайрга бутлах үед тоосжилт үүсэх

Хүснэгт 28. Агаарын чанарт үзүүлэх сорог нолооллийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн төвшин			
		Бага	Дун	Их	Сүйрлийн
1	Хөдөлгөөнт болон тэсэлгээний суурийн тоног төхөөрөмж, машин техник, тэслэгээний үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх			+	
2	Агаарын чанар өөрчлөгдөх		+		
3	Тоосжилтоос биологийн олон янз байдал үзүүлэх нөлөөлөл	+			
4	Агаар дахь тоосжилт хүн эрүүл мэндэд нөлөөлөх		+		

3.2.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ

Хүний үйл ажиллагааны нөлөөнөөс шалтгаалж ямар нэгэн химийн бодис болон биологийн элементээр хөрс бохирдож, хөрсөн дэх химийн бодис элементийн агууламж зөвшөөрөгдөх стандарт хэмжээнээс илүү болох үйл явцыг хөрс бохирдох гэнэ. Хөрс бохирдуулагч эх үүсвэрүүдэд янз бүрийн дэд бүтцийн байгууламжууд, техник тоног төхөөрөмжүүд, болон бусад сектороос ялгарч буй хорт нэгдлүүд, хог хаягдал, бохир ус гэх мэтийн үүсвэрүүд багтдаг.

Төслийн үйл ажиллагааны үед хөрсөн бүрхэвчинд дараах зүйлүүд нөлөөлнө.

- Төслийн нийт ашиглалтын хугацаанд 17,5 га талбайгаас үршил шимт хөрс хуулагдана. Гэхдээ тухайн төслийн талбай нь хад асгар нэм бэсрэг уулсын дунд байрлах учир дээр талбайгаас шимт хөрс хуулахад асуудал үүсэх магадлалтай. Иймд шимт хөрс хуулах боломжтой газраас давхар шимэрхэг хөрсийг хуулах шаардлагатай.
- Ашиглалт үед болон тээвэрлэлтийн үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр орчин тойронд тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч элэгдэлд орно.
- Шатах, тослох материалаар хөрс тодорхой хэмжээгээр бохирдоно.
- Байгалийн өнгө, төрх байдал өөрчлөгдөнө.

Хүснэгт 29. Хөрсөнд үзүүлэг сөрөг нөлөөллийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн төвшин			
		Бага	Дун	Их	Сүйрлийн
1	Машин техник, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс талхлагдах, бохирдох		+		
2	Хөрсний үндсэн хэв шинж өөрчлөгдөх		+		
3	Хөрс органик биш бохирдуулагч бодисоор бохирдсон байдал	+			
4	Хөрсөн дэх хүнд металлын агууламж	+			
5	Хатуу хог хаягдлаас хөрс бохирдох	+			

Дээрх дүнгээс харахад төслийн хэвийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх

нөлөөлөл нь ихэвчлэн бага болон дунд зэрэг, харин зам талбай усалгаа хийгээгүйн улмаас тоосжилт үүсэх аюулгүй ажиллагааны дүрэм журам баримтлаагүй үед бий болох нөлөөлөл эрсдэл маш байна.

3.2.4 Усан орчинд үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ

Хүснэгт 30. Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн төвшин			
		Бага	Дунд	Их	Сүйрлийн
1	Усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм зөрчих			+	
2	Булгийн усанд болон зориулалтын бус газар машин тенхик	+			
3	Усан дах хүнд металлын агууламж /асгаралт/	+			
4	Ил задгай хог хаягдал түүний улмаас усанд нөлөөлөх	+			
5	Шатахуун, хатуу, шингэн хог хаягдлаар газар доорх ус бохирдох		+		

Хүснэгтээс харахад нийт нөлөөллийн 60% нь бага зэрэг, 20% нь дунд зэрэг, 10 нь их гарч байгаа тул төслийн үйл ажиллагаанаас газар доорх усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл багаас дунд зэрэг байна.

Төслийн талбайд байгалийн гамшигт үзэгдэл, гэнэтийн осол, ажилчдын санамсар болгоомжгүй үйлдлээс шалтгаалан түлш, тос тосолгоо асгарсан дараах тохиолдлуудад хөрсийг бохирдуулж (тухайн бохирдлыг саармагжуулах, бууруулах арга хэмжээ аваагүй тохиолдолд) улмаар хур бороо орсон үед үерийн усаар дамжин Сухантын голыг бохирдуулж болзошгүй. Үүнд: Барилгажилтын үе шатанд: Барилга, байгууламжуудыг барих үед хэрэглэх барилгын материал (цемент, будаг, лак) асгарсан тохиолдолд;

Тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөс ШТМ асгарсан тохиолдолд хөрсийг бохирдуулж, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын усыг бохирдуулж болзошгүй.

Ашиглалтын үе шатанд:

- ШТС, ШТМ-ын агуулах, засварын газар, машины зогсоол, тээврийн хэрэгслүүдээс ШТМ асгарсан тохиолдолд;

3.2.5 Ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр талбай орчмын өвслөг ургамал дараах нөлөөллүүд үүснэ. Барилгын үйл ажиллагааны үед дараах хүчин зүйлс ургамлан бүрхэвчинд нөлөө үзүүлнэ.

Үүнд:

- Төслийн барилгын явцад хуулагдах талбайгаар хөрстэй хамт ургамалжилт үгүй болно.
- Техникийн нөлөөгөөр үүсэх тоосжилт нь ургамлын бодисын солилцооны эрчмийг бууруулах, улмаар ургамлын морфологид дараах өөрчлөлтүүд гарч болзошгүй. Үүнд:
 - Ургамлын зүйлүүдийн амсарын эс бөглөрөх, навч хорчийж хатах, хагдрах,
 - Фотосинтезийн эрчим буурч ургамлын өсөлт удаашрах, о Дээрх бүгдээс шалтгаалан ургамлын фотосинтезийн идэвхитэй хэсэг (газар дээрх)-ийн

хэмжээ багасаж, улмаар бүс нутгийн ургамлын биомассын хэмжээ буурах зэрэг болно.

Хүснэгт 31. Ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөө

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн төвшин			
		Бага	Дунд	Их	Сүйрлийн
1	Машин техник, хүний үйл ажиллагаагаар ургамлан бүрхэвч талхлагдах, устаж үгүй болох		+		
2	Барилгажилт төслийн ашиглалтын нөлөөгөөр ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл			+	
3	Тоосжилтын үзүүлэх нөлөө	+			

3.2.6 Дуу шуугианы нөлөөлөл

Ашиглалтын үе шатанд: Үйл ажиллагааны үед ашиглагдах гол тоног төхөөрөмж нь уурхайн бусад үйл ажиллагаанд ашиглагдах хүнд даацын тээврийн хэрэгслүүдээс бага дуу чимээтэй болно...

Тээврийн болон бутлуурын хэрэгслүүд нэгэн зэрэг ажиллахад нийлбэр дуу шуугиан 121.73 дБА, суудлын болон хөнгөн тээврийн хэрэгслүүд нэгэн зэрэг ажиллах үед гарах дуу шуугианы түвшин 78.9 дБА, эдгээр утгууд нь стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 18.9-61.73 дБА-аар бага буюу хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Бид Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн, уурхайн ашиглалтын үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө зэргийг үндэслэж тухайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Чухамжараглан ХХК нь “Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт хуулийн хүрээнд байгаль орчны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн тус төслийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад оршино

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ нь SGMV-00009 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарна.

5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Чухамжаргалан” ХХК -ийн Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших SGMV-00009 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Хөвийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А-618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” зэрэгт тулгуурлан боловсруулсан болно

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардалд 23 600 000(Хорин гурван сая зургаан зуун мянга) төгрөг төсөвлөгдсөн.

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	2024 он сая.төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3.1
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10.0
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5.0
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Хийгдсэн
6.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	0.5
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2.0
8.	Удирдлага зохион байгуулалт	-
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3.0
Тухайн жилийн зардал, сая төг		23.6

5.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 32. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Зардал мян.төг 2024 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйл ажиллагааны үе шатанд	Агаарын чанар	<ul style="list-style-type: none"> Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох Уурхайн үйл ажиллагаанд оролцох машин техникээс хорт агууламж бүхий утаа ялгарах 	<ul style="list-style-type: none"> Тоос дарах төхөөрөмж буюу мананжуулагч байрлуулах эсвэл усалгааг ажил эхлэхийн өмнө хийж байх Агаарын бохирдол болон орчны бохирдлыг хэмжих дотоод хяналтын багаж хэрэгсэлтэй болох 	Уурхайн талбайд Баяжуулах болон тээврийн зам орчимд	Дотоод төсөв 500.0	2024	-
	Гүний ус	<ul style="list-style-type: none"> Шатах тослох материалыг алдснаар хөрсийг бохирдуулснаас газрын доорхи ус бохирдох 	<ul style="list-style-type: none"> Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах https://hsct.mn/ 	Каррьер, засварын газар	1000.0	2024	Усны тухай хууль MNS 2662-2002
	Хөрсөн бүрхэвч	<ul style="list-style-type: none"> Шатах тослох материал асгарах, гэнэтийн болзошгүй 	<ul style="list-style-type: none"> Хөрсөн бүрхэвчийг талхагдахаас сэргийлж олон 	Уурхайн талбайд	600.0		MNS “5917:2008”

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Зардал мян.төг 2024 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
		аваар осолоос үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	салаа зам үүсгэхгүй байх, нэгдсэн замын хөдөлгөөний сүлжээ зураг самбар тавих • ШТС олголтын талбайд хайрга дайрга асгаж хөрсөн бүрхэвчийг хамгаалах			2024	
	Ургамлан нөмрөг	• Уурхайн үйл ажиллагаанаас ургамалан бүрхэвч доройтох	• Жил бүр ургамлын судалгаа мониторинг явуулах, нөхөн сэргээлт хийхэд тохиромж үрийг орон нутгаас худалдан авах, үрийг түүх	Уурхайн талбайд	Урсгал зардлаар	Жил бүр	MNS 5918:2008
	Амьтны аймаг	• Уурхайн ухааш болон уурхайн талбайд зэрлэг амьтад нэвтрэх, улмаар нүх рүү унаж гэмтэх, хог хаягдлаас хордох • Нөхөн сэргээлтийг журмын дагуу хийгээгүйгээс	• Уурхайн овоолго болон ухаашын гадуур хамгаалах хайс, тор татах • Ажилчдад амьтны тухай хууль, байгаль хамгаалах	Уурхайн талбай, бутлах үйлдвэрийн орчимд	Урсгал зардлаар	Жил бүр	Амьтны тухай хууль

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Зардал мян.төг 2024 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
		амьдрах орчин доройтох	талаар сургалт хийж байх				
		<ul style="list-style-type: none"> Уурхайн ажилчид хууль бусаар амьтан агнах үйлдэл гаргах 	<ul style="list-style-type: none"> Ажилчдын тосгонд галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэглэхийг хориглох 				
		<ul style="list-style-type: none"> ЦДАШ-ыг шувуу мөргөх, тогонд цохиулах 	Шувууны нислэгийн чиглэл өөрчлөгч /үргээгч/ болон шувууны суулт /үүр/ суурилуулах	ЦДАШ-ын дагуу	1000.0	Нийт 10 удаа- Жилд 2-3ширхэг	Амьтны тухай хууль
Нийт					3100.0		

5.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Жил бүр 10 сая төгрөг нөхөн сэргээлтэд зориулан хуримтлуулна.

5.3 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих үеэр тус уурхайн орчимд биологийн олон янз байдлын судалгаа шинжилгээ хийх, гарсан үр дүнд тулгуурлан биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө, дүйцүүлэн хамгааллын стратеги боловсруулж Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагын холбогдох мэргэжилтнүүдэд албан ёсоор танилцуулж, тэдгээрийн саналыг авч тайланд тусган ажиллаж байна. Энэхүү биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө, дүйцүүлэн хамгааллын стратегийн хүрээнд төлөвлөгөө, хөтөлбөрийг орон нутгийн захиргааны саналыг тусгаж хэрэгжүүлэх ёстой.

Хүснэгт 33. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдэх ажил

Дүйцүүлэн хамгааллын стратеги	Гүйцэтгэх ажил	2024 онд
Биотехникийн арга хэмжээ	Багийн түвшинд орон нутгаас чиглэл өгсөн газарт зэрлэг амьтдад зориулж өвс хужир мараа тавьж өгөх, орон нутгийн байгаль хамгаалагчтай хамтран ажиллах	5000.0
	Нийт мян.төг	5000.0

5.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн 500 метр дотор эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд албан ёсоор газрын гэрчилгээ авсан Иргэн Батдалайгийн эзэмшил газар багтаж байна. Гэвч тус айл нь өөрийн эзэмшлийн газарт ямар нэгэн малын хашаа хороо, амьдран суух гэр одоогоор байхгүй бөгөөд бага зэргийн хог байна. Цаашид тус айл энэ нөлөөллийн бүсэд ирж суурьших юм бол тоосжилт болон дуу чимээний нөлөөлөл байна. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлангийн 2024-2028 оны хүрээнд тухайн айл эзэмшил газартаа суурьшсан тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтийг хийхдээ Монгол улсын Иргэний хуулийн дагуу нөлөөлөлд өртсөн айлд 20 сая төгрөгийн нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговрын зардал болгоно.

5.5 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг авран хамгаалах ажлыг зохион байгуулсан болно.

5.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 34. осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Ажилчдад ХАБЭА-ны ажлын хувцас, малгай, хошуувч, гутал	Уурхайн бүх ажилчдад	-	Дотоод төсөвд тусгасан	Өдөр бүр, тогтмол	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1
	Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн бүх ажилчдад	-	500.0	Сургалтыг 1 удаа	
НИЙТ				500.0		

5.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 35. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	4жилийн нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх, Хог хаягдлын төлбөрийг цаг тухай бүрд төлөх	Хог хаягдлын ангилсан цэгийг засч тохижуулах	-	300.0	4	1200.0	Жил бүр	Хог хаягдлын тухай шинэчилсэн хууль 2017.05.12
2.	Үйлдвэрийн	Төслийн талбайн орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байрлуулах, Байр сууц бүрт орчинтойгоо зохицсон материал, өнгө үзэмж бүхий хогийн савтай байх	Хог хаягдлын ангилсан цэгийг засч тохижуулах	-	-	-	Дотоод төсөв	2024 онд	
3.	Аюултай	-Хог хаягдлын ангилсан цэгт төмөр битүүмж бүхий тагтай төмөр саванд хадгалах	Аюултай хог хаягдал	-	-	-	Дотоод төсөв	Жил бүр	
4.	Шингэн	-Шингэн хог хаягдлыг зайлуулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх -Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл гаргуулах	Цаг хугацаанд бохир зайлуулах гэрээний дагуу зайлуулах	-	400.0	2	800.0	Жилд 2 удаа	
	Нийт						1 жилд 2000.0		

5.8 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 36. БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Удирдлага зохион байгуулалт	Ажиллагсадыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгсэлээр хангах	Уурхайн ажилчид	Дотоод төсөв	--*--	Тухай бүрд
НИЙТ				--*--	

5.9 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Чухамжаргалан” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Чухамжаргалан” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Агаарын чанар					
1.1	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 1 цэг сонгох	Агаарын найрлага: 6,9 саруудад	Гэрээт байгууллагаар хийлгэх 1жилд нийт 1600.0	<ul style="list-style-type: none"> - MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, - MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, - MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх эсвэл өөрсдөө баримтжуулан зураг дарж тэмдэглэл хөтлөх		Тоосны хяналт: -Олборлолтын талбайд -Хүнд даацын машины дотоод замд 6,9 саруудад	Гэрээт байгууллагаар хийлгэх 1жилд нийт 4800.0	
1.3	Дуу шуугиан, чичиргээ: -Хүнд даацын машины тээврийн зам, -Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		6,9 саруудад	1жилд нийт 1200.0	
2. Усны хяналт шинжилгээ					
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ, бактериологи	Унд ахуйн усыг хангаж буй гадаргын усыг	Жилд 2 удаа 6,9 саруудад -ундны усны оролт - ундны усны гаралт -бохир	200.0*2 удаа 1жилд нийт 2000.0	<ul style="list-style-type: none"> - MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж - MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага - MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж - MNS 13.060.50 Усны чанарын стандарт - MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3. Хөрсний бохирдол					

3.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайд 2 цэг сонгох /Овоолго болон олборлолт явуулж буй талбайн ойролцоо/	- Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 1 удаа - Жилд 2 удаа - 6, 9 саруудад	1 цэгт х 3 дээж х жилд 2 удаа х 1 жилд нийт 2400.0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -хүнд металлын шинжилгээ 1 дээж	<ul style="list-style-type: none"> - MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, - MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга - MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга - MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4. Ургамал болон Амьтны аймаг					
4.1	Ургамал, Амьтны аймаг	Төсөл хэрэгжих орчинд	Төсөл хэрэгжих хугацаанд	-	-
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖИЛИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН				3000.0	

5.10 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ


Уурхайг ашиглах явцад байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс зайлс хийх, бууруулах, нөхөн сэргээх арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллана.

БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Аймаг, Багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг	-
БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор бат



МОНГОЛ УЛС
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2009.06.24
/Бүртгэсэн он, сар, өдөр/

1111003044
/Улсын бүртгэлийн дугаар/

3614093
/Регистрийн дугаар/

Чухамжаргалан
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Шийдвэр
/Шийдвэрийн нэр/

01
/дугаар/

2009.06.20
он, сар, өдөр

519000
/код/

Гадаад дотоод худалдаа
/Хөдөлгөөний үйл ажиллагааны чиглэл/

код/


/Гуулах эрхтэй үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй
хугацаа

2
/Гишүүдийн тоо/

1,180.0
/Өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган тэгрөгөөр/

Өмнөговь, Даланзадгад, Далан баг, Хөдөлмөр хангамж үйлчилгээний хэлтэс - 2 давхарт, утас: 99074919,
утас: 99292111, факс:
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/



Өмнөговь аймгийн татварын хэлтэс
/Бүртгэсэн байгууллагын нэр/

Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан, төлдөг
ХАА Өмнөговь салбар	Төгрөгийн	5585396952	Ц.Сүрэнтуяа

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Огноо	Бүртгэсэн Ажилтан, тэмдэг
1	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 2 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2015.01.17	М.Энхтөгтох
2	Оюуницэцэ овогтой Хишигбат-г Захирал-р томилсныг бүртгэв.	2015.01.17	М.Энхтөгтох
3	Өмнөговь, Гурвантэс, 2-р баг, Баясах, . . . 0 тоот, Утас1 94737373, Утас2, Факс хаягийг шинээр бүртгэв.	2015.01.17	М.Энхтөгтох
4	4390 Барилгын засвар хийх эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 4323 Авто машиныг ачаа тээвэрлэх эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 4320 Авто машины сэлбэг эд ангийн худалдаа эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 8130 Тээвэрлэгчжүүлэлт, зүлэгжүүлэлт эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2015.01.17	М.Энхтөгтох
5	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.09.03	Б.Должинсүрэн
6	Оюуницэцэ овогтой Алтанбагана-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2020.09.03	Б.Должинсүрэн
7	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2020.09.03	Б.Должинсүрэн
8	Хувьцаа эзэмшигч 3 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.12.24	М.Энхтөгтох
9	Оюуницэцэ овогтой Хишигбат-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2020.12.24	М.Энхтөгтох
10	Эцсийн өмчлөгч 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.12.24	М.Энхтөгтох
11	Хувьцаа эзэмшигч 3 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2021.06.29	М.Энхтөгтох
12	Эцсийн өмчлөгч 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2021.06.29	М.Энхтөгтох
13	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 3 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2022.10.26	М.Энхтөгтох
14	Эцсийн өмчлөгч 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2022.10.26	М.Энхтөгтох
25	4669 Гадаад х, Залдаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 08100 Түгээмэл тархайттай ашигт малтмал ашиглах /2018.12.31-2033.12.31/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2022.10.26	М.Энхтөгтох
16	Хувьцаа эзэмшигч 3 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2023.01.02	М.Энхтөгтох
17	Амгэрзана овогтой Тэмүүлэн-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2023.01.02	М.Энхтөгтох
18	Эцсийн өмчлөгч 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2023.01.02	М.Энхтөгтох

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРЬЫН
ТАМГЫН ГАЗАР
ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар SGMV-00009

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн
19.5дахь хэсгийг үндэслэн

_____ Өмнөговь _____ аймаг /нийслэл/-ийн

_____ Гурвантэс _____ сум /дүүрэг/-ын

_____ Хөв _____ нэртэй газарт орших

_____ 103.9 _____ гектар талбайг хамарсан

түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайд хуульд заасан
нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч
улсын бүртгэлийн _____ 1111003044 _____ тоот
гэрчилгээтэй

" _____ Чухамжаргалан _____ " ХХК

_____ -д

энэхүү тусгай зөвшөөрлийг _____ 15 _____ жилийн
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА _____ Н.НАРАНБААТАР

2018 оны 12 сарын 31-ны өдөр

Даланзадгад сум



**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол
хүчингүй.**

**Тусгай
зөвшөөрлийн
дугаар SGMV-00009**

Хөдөлгөөний код	Хөдөлгөөний тайлбар	Гарын үсэг, огноо, тамга
Тусгай зөвшөөрөл олгосон Төлбөр	<ul style="list-style-type: none"> Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/1537 дугаар захирамжаар 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдөр зөвшөөрөл олгов. Анхны хугацааг 2018 оны 12 дугаар сарын 31-аар тооцно. Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөр төлсөн 	<p>2018-12-31</p> <p>2018-12-31</p> <p>ТТБ.м.2337</p>
Төлбөр	<ul style="list-style-type: none"> Тусгай зөвшөөрлийн 2 дахь жилийн төлбөр төлсөн Тусгай зөвшөөрлийн 3 дахь жилийн төлбөр төлсөн Тусгай зөвшөөрлийн 4 дахь жилийн төлбөр төлсөн Тусгай зөвшөөрлийн 5 дахь жилийн төлбөр төлсөн 	<p>2019-12-05</p> <p>2020-12-23</p> <p>2021-12-10</p> <p>2022-10-05</p>
	<ul style="list-style-type: none"> 	
	<ul style="list-style-type: none"> 	
	<ul style="list-style-type: none"> 	



**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ**

Тусгай
зөвшөөрлийн
дугаар SGMV-00009

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг						
				#	Уртраг			Өргөрөг		
1	<ul style="list-style-type: none"> 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдөр тусгай зөвшөөрөл олгов. 	103.9	0.0 га	1	101	19	2.5	43	2	55.5
				2	101	18	31.5	43	2	55.5
				3	101	18	31.5	43	3	43.5
				4	101	19	2.5	43	3	43.5
								2018-12-31		



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР
ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 00022Х

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг үндэслэн

Өмнөговь аймаг /нийслэл/-ийн
Гурвантэс сум /дүүрэг/-ын
Баянгол нэртэй газарт орших
316 гектар талбайг хамарсан
түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайд хуульд заасан
нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал хайхыг зөвшөөрч улсын
бүртгэлийн 1111003044 тоот гэрчилгээтэй
" Чухамжаргалан " -д
энэхүү тусгай зөвшөөрлийг 3 жилийн
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Б.БАДРАА

2015 оны 10 сарын 20 өдөр

Даланзадгад хот



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар **0011824**

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: *"Чухамжаргалан" ХХК*

Хаяг: *Өвчинговь аймал Турвантэж сум*

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

Барилгын чулууны үйлдвэрлэл

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, / гал унтраах автомат болон
дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж /анхан шатны багаж хэрэгсэл,
бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/

Олгосон: *2023* он *07* сар *26* өдөр

Хүчинтэй хугацаа: *2025* он *07* сар *26* өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

Өвчинговь ОБТ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга *Хурандаа* цолтой *М. Агваабалатар*

Дүгнэлт гаргасан:

Өвчинговь Турвантэж аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч: *Хонхуу* цолтой *Д. Монхзул*



САНАМЖ

- Галын аюулгүй байдлын дүгнэлтийг үйлчилгээний танхимд хүний нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна.

- Галын аюулгүй байдлын дүгнэлт нь үнэт цаас учраас үрэгдүүлж, гэмтээлгүй хадгалахаас гадна хувилж, олшруулж, хуурамчаар үйлдвэрлэсэн болон бусдад түрээслэх, худалдсан тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

- Галын аюулгүй байдлын дүгнэлт нь банкны зээлийн баталгаа, барьцаа болохгүй.

- Галын аюулгүй байдлын дүгнэлт нь Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан норм, дүрэм, стандартыг зөрчсөн тохиолдолд Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан хураан авах, цуцлах эрхтэй.

- Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссанаас хойш 1 сарын хугацаанд дахин сунгуулах.



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН НУТАГТ ОРШИХ ХӨВИЙН БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ТОДОТГОЛ

Тусгай зөвшөөрлийн талбайн дугаар: SGMV-00009
Хүчин чадал: 140.0 мян.м³/жил

ХЯНАСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *З. Хууч* Ч.ХУЛАН/

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН:

"ГОУЛДМЭН ПРОЖЕКТ" ХХК
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

ЗӨВЛӨСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР

ШИНЖЭЭЧ:

МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР

ТӨСЛИЙН БАГ:

УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР

УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР

БАЯЖУУЛАЛТЫН ИНЖЕНЕР

Улаанбаатар хот
2023 он

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ХӨВ БАРИЛГЫН ЧУЛУУНЫ” ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ
ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛД ХИЙСЭН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ**

2019 оны 05-р сарын 07

Улаанбаатар хот

SGMV-00009 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд орших Хөв нэртэй барилгын чулууны ордыг ашиглах Техник-эдийн засгийн үндэслэлийг “Чухамжаргалан” ХХК-ийн захиалгаар “Майндата” ХХК боловсруулжээ.

ТЭЗҮ нь оршил, геологийн хэсэг, уул технологийн хэсэг, баяжуулах технологи, уурхайн усан хангамж, уурхайн цахилгаан хангамж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, уурхайн хаалтын төлөвлөлт, байгаль хамгаалах, нөхөн сэргээх, эдийн засгийн үр ашиг гэсэн 12 бүлэг, 95 хуудас тайлбар бичиг, хавсралт тооцоо, холбогдох эрх зүйн баримт бичгүүд, хүснэгт, зургуудаас бүрдсэн байна.

Төсөлд тусгасан дараах асуудлуудад шинжээчийн зүгээс тодотгол хийх, засварлах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардал байгаа эсэх. Хэрэв байгаа бол төсөлд тусгаж өгөх.
2. Хаягдал бохирдлын тооцоог харахад хаягдал нь 0.3%, 3% юмуу үүнийг нэг мөр болгох
3. Ашиглалтын дэвсгэр зураг яагаад 1:2000 масштабээр байгаа бэ? Үүнийг том масштабтай болгох мөн мөргөцөг тэмдэглсэн тэмдэглэгээ буруу байна. Үүнийг шинээр зурах
4. Ил уурхайн хажуугийн өнцөгийн тооцоо болон ажлын доголын өнцөгийн тооцоог оруулах. Яагаад ажлын доголын өнцөг 80-70 градус байгаа вэ? мөн ажлын бус догол 65 градус байна хаанаас энэ тооцоог гаргаж ирсэн вэ тэр тооцоог оруулах.
5. Ажлын талбайн өргөн хаанаас 20 метр гэж тооцсон вэ? Тэр тооцоог оруулах
6. Уурхайн доголын тоог олох тооцоонд гүн 50 метр гэсэн байна. Гэтэл зүсэлтээс харахад өөр гүнтэй байна. Үүнийг тодруулах.
7. Нийт хөрсний хэмжээг хаанаас тооцож гаргасан вэ? Энэ талаарх тоог нөөцийн дүгнэлт болон бусад зүйлээс хайгаад олсонгүй. ТЭЗҮ-д тусгах
8. Өрмийн машиний маркыг CM-358 юм уу CM853 юм уу? метр цооног өрөмдөх хугацаа хаанаас бодож 0.02 цаг гэж олсон вэ? Тэгвэл ээлжийн бүтээл зөв үү
9. Хуудас 42 нонель хаачив.
10. Цахилгаан хангамж хаанаас яаж авах бэ?
11. Эдийн засгийн тооцоо дээр нэгдсэн дүн харагдаж байна. Задаргааг харуулах.
12. АМНАТ- 2.5 хувь биш үү

Санал:

“Чухамжаргалан” ХХК-ийн захиалгаар “Майндата” ХХК боловсруулсан Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших “Хөв барилгын чулууны” ордыг ил уурхайн аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэл” төсөлд шинжээчийн дээр дурьдсан асуудлуудыг анхаарч тодруулга, засвар хийлгэснээр тус ТЭЗҮ-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх боломжтой гэж үзэв.

Шинжээчийн дүгнэлт гаргасан:

Уул уурхайн мэргэшсэн инженер Б.Баяраа

105

Батлав: "ЧУХАМЖАРГАЛ" ХХК-ний
Гүйцэтгэх захирал...../А.Тэмүүлэн/



Зөвшөөрөв: Өмнөговь аймгийн
Засаг дарга...../Р.Сэддорж/



2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

(Тусгай зөвшөөрлийн талбайн дугаар: SGMV-00009)

Аймаг.Өмнөговь
Сум.Гурвантэс
Уурхайн нэр.Хөв

ТАНИЛЦСАН:

АМИТГ-ын Говийн бүсийн төлөөлөгчийн газрын дарга...../Э.Ганхуяг/ Э.Ганхуяг

ХЯНАСАН:

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын ГУУХУ-ын байцаагч...../Ц.Отгонгэрэл/ Ц.Отгонгэрэл

БОЛОВСРУУЛСАН:

Төлөвлөлтийн инженер...../Д.Бямбадорж/ Д.Бямбадорж

2023 он



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

Чэнгээлэвчын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 28 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2024.04.25 № 01/501
танай 2024.04.20 -ны № 24/04 -т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Танай байгууллагын 2024 оны 24/04 тоот албан хүсэлт, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших "Чухамжаргалан" ХХК-ийн ашиглалтын SGMV-00009 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий "Хөвийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлангийн төсөл болон холбогдох бусад материалыг судлан үзээд Усны тухай хуулийн 16¹.4.10 дахь заалтыг үндэслэн ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Цаашид үйл ажиллагаа явуулахдаа Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 28 дугаар зүйлийн 28.4, 30 дугаар зүйлийн 30.1, 30.2 дахь заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөж байна.

Хувийг: Алтайн өвөр говийн сав газрын захиргаанд

Хавсралт: 2 хуудастай.

Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө, усаа хамгаалъя, хуримтлуулъя, хамтран ажиллая.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.БАТБАЯР

162420955

УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТ

2024 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот
Утас: 51-265526, 265528

1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

"Чухамжаргалан" ХХК, Өмнөговь аймаг, Даланзадгад хот, Далан баг, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн 2-р давхар, холбогдох утасны дугаар: 99074919, 99292111, улсын бүртгэлийн дугаар: 1111003044, регистрийн дугаар: 3614093.

2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:

"Төгрөг баян хангай" ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Хоймор оффис, 5-р давхар, 505 тоот, холбогдох утасны дугаар: 70168088, 88034734.

3. Төслийн нэр, байршил:

"Хөвийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах" төсөл. Орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 810 км, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын төвөөс урагш 40 км, "Монголын алт МАК" ХХК-ийн Нарийн сухайт нүүрсний уурхайн ашиглалтын талбайгаас хойш 4 км, Шивээхүрэнгийн боомтоос хойш 45 км зайд байрлана. Алтайн өвөр говийн сав газрын захиргаанд хамаарагдана.

4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын "Хөв" нэртэй газарт SGMV-00009 дугаартай түгээмэл тархацтай ашигт ашиглалтын SGMV00009 дугаартай тусгай зөвшөөрлийг Өмнөговь аймгийн Засаг даргын 2018.12.31-ний өдөр 15 жилийн хугацаагаар "Чухамжаргалан" ХХК-д олгосон.

5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:

"Хөв" барилгын чулууны ордын бутлуурын цехийн жилийн хүчин чадал 140.0 мян.м³. Уурхайд жилд 2 ээлжээр. 76 хүн. 350 хоног ажиллана.

6. Усны эх үүсвэр, байршил:

Уурхайн ажилчдын унд, ахуйн усны хэрэглээ, ил уурхайн зам, талбайн тоосжилт дарах усалгаа болон ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд шаардлагатай усны хэрэглээг "Бласт" ХХК-тай байгуулсан гэрээний дагуутус компанийн худгуудаас хангана.

Худгийн байршил: 101°13'07.33", 43°14'16.70"; ундарга: 1 л/с

101°13'07.32", 43°1'16.47"; ундарга: 3 л/с

7. Ашиглах усны хэмжээ:

Төслийн усны хэрэгцээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм" болон Өмнөговь аймгийн аймгийн Гурвантэс сумын нутагт орших "Хөв"-ийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлангийн төсөлд үндэслэн тооцоход:

Унд, ахуйн ус хэрэглээнд:

- 76 хүн x 80 л/хон = 6.08 м³/хон x 350 хон = 2,128 м³/жил

Зам, талбайн тоосжилт дарах ус хэрэглээнд:

- 6,000 м² x 2 л/м² = 12 м³/хон x 40 удаа = 480 м³/жил

Биологийн нөхөн сэргээлтэд:

- 39,000 м² x 4.0 л/м² = 156 м³/хон x 10 удаа = 1,560 м³/жил

Ногоон байгууламжийн усны хэрэглээнд:

- 100 ш.мод x 40 л/ш.мод = 4.0 м³/ш.мод x 24 удаа = 96 м³/жил

Нийт ус ашиглалт: 178 м³/хон (4,264.0м³/жил)

8. Дүгнэлт:

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших "Чухамжаргалан" ХХК-ийн "Хөвийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах" төслийг хэрэгжүүлэхэд унд, ахуй, зам, талбайн тоосжилт дарах, биологийн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн 178 м³/хон усны хэрэглээг 4.0 л/сек ундаргатай 2 ш гүний худгаас усаар хангахад нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

9. Тавих шаардлага, цаашид өвөх өрсө хэмжээ, зөвлөмж:

Төслийг хэрэгжүүлэхдээ Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 28 дугаар зүйлийн 28.4, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.3, 30.1.4, 30.1.5, 30.2.2, 30.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахыг "Чухамжаргалан" ХХК -д зөвлөж байна.

УСНЫ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ц.ОЮУНТӨГС



**МОНГОЛЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ
ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБОО**

Бага тойруу-26/1, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо
Шуудангийн хайрцаг: Улаанбаатар 14192/338

Утас/факс: +976 11 316253

Вэб сайт: www.bmat.mn

И-мэйл: bmataassociation@mongolnet.mn

2018-06-20 № 2/081
танай _____-ны № _____-т

Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт орших "Хөв"ийн барилгын чулууны ордод 2017 онд хийсэн эрэл хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн түүхий эдийн чанар -технологийн дүгнэлт

"Чухам жаргалан" ХХК-ний Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт орших "Хөв"ийн барилгын чулууны ордын 2017 онд 00024X хайгуулын тусгай зөвшөөрөлтэй нийт 144.8 га талбайд тус компаний хөрөнгөөр зөвлөх инженер геологич С.Энхболд, геологич инженер Н.Жавхлантай нарын геологийн хэсэг эрэл хайгуулын ажлыг хийж нөөцийг бодит В зэргээр 1151202 тонн, боломжит С зэргээр 377001,3 тонноор тогтоосон байна. Эрэл хайгуулын хүрээнд 2 шугамын дагуу 100х50 метрийн хайгуулын торлоор 30,0 метрийн гүнтэй 8 цооног буюу 240.0 тууш метр баганат өрөмдлөгийн ажил хийсэн байна.

Өрөмдлөгийн кернээс 5 метрийн интервалаар сорьц авч "Барилга архитектур корпораци" ХХКомпаний итгэмжлэгдсэн лабораторид дайрганы физик-механикийн хураангуй шинжилгээнд 40, бүрэн шинжилгээнд 8, бат бэхийн судалгаанд 8, химийн шинжилгээнд 4, урвалжих чадвар, сульфатад тэсвэрлэлт, хүйтэнд тэсвэрлэлтийн шинжилгээнд 6, лаборатори технологийн судалгаанд 1, Геологийн төв лабораторид эрдсийн судалгаанд 3, УМЕГазрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн цацрагийн элементийн лабораторид 1 дээж тус тус өгч дүнг хавсаргасан байна.

"Барилга архитектур корпораци" ХХКомпаний итгэмжлэгдсэн лабораторид автозамын зориулалтаар ашиглах зорилгоор авто замд мөрдөгдөж буй стандартуудын дагуу хийлгэсэн шинжилгээнүүдийн үзүүлэлтүүдийг Барилга байгууламжийн ажилд хэрэглэх дайрга, техникийн ерөнхий шаардлага MNS 390.98, Хүнд бетонд хэрэглэх дүүргэгч материал. Техникийн шаардлага MNS 2803:2004, MNS 1170-2009, MNS 1272-99 стандартуудын үзүүлэлтүүдтэй харицуулж дүгнэхэд:

1. "БАК" ХХКомпаний итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр:

- Дайрганы ширхэгийн дундаж нягт 2.63г/см³,
- Асгаасны эзэлхүүн жин дунджаар 1312 кг/м³
- Нимгэн үзүүлэлэг шовх хэсгийн агуулга ордын дундаж 1,33 % байгаа нь дайрганы ширхэгийн хэлбэрийн ангилалын "шоо" хэлбэрийн ангилалд багтана,

- Бутлагдалтаар тогтоосон марк Б-8 марк,
- Чийг 0,1 %
- Ус шингээлт дунджаар 0,74 %,
- Тоос, шавар, шорооны агуулга нийт дээжинд дунджаар 0,34%
- Ширхэг хоорондын зай дунджаар 50,1% ,
- Шахалтын бат бэх дунджаар 1200Кгх/см²
- Дээжинд хийсэн хүйтэнд тэсвэрлэлт 3,1%, элэгдэх чанар нь дунджаар 22 % зэрэг үзүүлэлтүүд нь дээрхи стандартуудын шаардлагыг хангаж байна.

2. Физик механикийн хураангуй шинжилгээний дүнгийн ширхэглэлийн бүрэлдэхүүнээс харахад 20,0 мм ширхэглэл хамгийн их буюу 84,5 % , 5мм –ийн ширхэглэл 1,37 % байгаа нь 20-40 мм-ийн ширхэглэлийг дахин буталж шигших замаар бетоны найрлагад шаардагдах нарийн ширхэглэлтэй механик элс гаргаж авахаар тооцож технологийн тоног төхөөрөмжийн сонголт хийх шаардлагатайг харуулж байна.

3. Бетоны найрлагыг тогтоосон үзүүлэлтээр MNS 1170-2009, MNS 1272-99 стандартын дагуу тус ордын буталсан дайргаар В30 /400/ маркийн бетоны дүүргэгч болон авто замын суурь үед ашиглах боломжтой гэж үзэж байна

4. Геологийн судалгааны төвийн Чулуулаг , эрдэс судлалын лабораторид хийсэн петрографын шинжилгээний дүнгээр , алевролитлаг , базальтлаг структуртай , цул текстуртай, жижиг-том ширхэгтэй, кварц, хээрийн жоншт алевролитийн төрлийн чулуулаг болохыг нотолсон байна.

5.Цацраг идэвхит радийн эквивалентийн идэвхийн дундаж хэмжээ стандартаар зөвшөөрсөн хэмжээнээс 4,1 дахин бага буюу 90 Бк/кг байгаа нь (Сэкв<370Бк/кг) барилгын материалын 1-р зэрэглэлд хамрагдах бөгөөд авто замаас гадна орон сууц, үйлдвэр, аж ахуйн зориулалттай барилгын материал үйлдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Иймд "Чухам жаргалан"ХХК-ний захиалгаар "Хөв"ийн барилгын чулууны ордод хийгдсэн хайгуулын ажлын тайланг АМГТГазрын Эрдэс баялгийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг БМҮХолбооны техникийн зөвлөлөөс дэмжиж байна.

Гүйцэтгэх захирал

Шинжээч



МОНГОЛ УЛС
10-719
111-03548
О. Дягвадорж
Барилгын холбогч материалын технологич
(Инженер, Техникийн ухааны магистр)
Зөвлөл
Инженер
БМ.Б
2017-2022
Н.Оч

Монгол улсын барилгын материалын
Зөвлөлх инженер, Техникийн ухааны магистр)

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших барилгын чулууны
"Хөв"-ийн ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан



**БАРИЛГА АРХИТЕКТУР КОРПОРАЦИ
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**



TL 13

2017 оны Есдүгээр сар 27 645/17 БДЦ Улаанбаатар хот

БЕТОН ДҮҮРГЭГЧ, БАРИЛГЫН ФИЗИКИЙН ЛАБОРАТОРИ

Захиалагч байгууллага : "Чухам Жаргалан"ХХК
Дээжийн нэр : Дайрга
Орд газар : Өмнөговь, Гурвантэс, Хөв
Дээж ирүүлсэн : 2017.09.11
Туршилт хийсэн хугацаа : 2017.09.13-09.22
Шинжлэхэд мөрдсөн стандарт : MNS 2998-2009
Хуудасны тоо нийт/тухайн : 5/5

Хураангуй шинжилгээний үр дүн:

№	Дээжийн дугаар	Аслагчийн эзэлхүүн жинг, кг/м³	Чийг, %	Өсөрөг хэсэг, %	Буримдсан хэсэг, %	Нийлэг үзүүрлэг хэсэг, %	Тоос, шавар, шороо, %	Буграмтгай зангар, %	Ширхэгийн бүрэлдэхүүн, мм (шилжүүр дээрхи хэсгийн болон бүрэн үлдэг, %)			
									40	20	10	5
33	ХШ-2, Ц-7, Д-39	1346	0.2	0.0	100	0.6	0.4	10.7	9.6	86.4	4.0	-
									9.6	96.0	100	-
34	ХШ-2, Ц-7, Д-40	1347	0.1	0.2	100	1.5	0.4	10.5	13.6	79.3	6.9	0.2
									13.6	92.9	99.8	100
35	ХШ-2, Ц-7, Д-42	1307	0.2	0.0	100	0.8	0.5	10.8	26.0	72.6	1.4	-
									26.0	98.6	100	-
36	ХШ-2, Ц-8, Д-43	1339	0.1	0.1	100	0.8	0.3	8.8	23.7	75.7	0.6	-
									23.7	99.4	100	-
37	ХШ-2, Ц-8, Д-44	1329	0.2	0.1	100	0.0	0.5	8.5	29.2	70.2	0.6	-
									29.2	99.4	100	-
38	ХШ-2, Ц-8, Д-45	1297	0.1	0.2	100	0.3	0.1	11.2	14.1	83.1	2.8	-
									14.1	97.2	100	-
39	ХШ-2, Ц-8, Д-47	1337	0.2	0.0	100	0.0	0.1	10.0	26.9	72.6	0.5	-
									26.9	99.5	100	-
40	ХШ-2, Ц-8, Д-48	1344	0.2	0.1	100	1.4	0.1	10.6	13.9	83.1	2.9	0.1
									13.9	97.0	99.9	100

Шинжилгээний дүн нь захиалагчаас ирүүлсэн зөвхөн энэ дээжид хамаарах ба шинжилгээний дүнг олон удаа хариуцан хувилахыг хориглоно.

Лабораторийн эрхдэгч /Б.Өлзийбүрэн/
Шинжилгээ хийсэн: /Б.Сарантуяа/
/Д.Сайдагдорж/

Монгол улс, Улаанбаатар хот
ХУД, 2-р хороо Чингисийн Өргөн чөлөө

Утас: 11341530
70131534



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар Т/97

Улаанбаатар хот

Техник, эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Т/23-10-04 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Чухамжаргалан ХХК-ийн SGMV-00009 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Хөв" нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авсугай.

2. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Чухамжаргалан ХХК-ийн SGMV-00009 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Хөв" нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хуулсан дискийг төсөл эзэмшигчээс хүлээн авахыг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.БАЯРМАНДАЛ





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРНИЙ ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2025 оны 07 дугаар сарын 05

№ 7/25-10-04

Улаанбаатар хот

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших SGMV-00009 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Хөв" нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцсэн тухай

Чухамжаргалан ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн Гоулдмэн Прожект ХХК боловсруулсан Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших "Хөв" нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголд Монгол Улсын зөвлөх инженер Г.Тулга зөвлөж, Монгол Улсын зөвлөх инженер Я.Доржсүрэн, Уул уурхайн мэргэжсэн инженер Г.Батзаяа нар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.
2. Техник, эдийн засгийн үндэслэл нь уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүх шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.
3. Техник, эдийн засгийн үндэслэл нь Төслийн танилцуулга, Ерөнхий мэдээлэл, Ордын судлагдсан байдал, геологийн тогтоц, нөөц, Олборлолтын технологи, Ангилан ялгах хэсэг, Дэд бүтэц, барилга байгууламж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Уурхайн ажиллах хүч, хүний нөөц, Байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ зэрэг 11 бүлэг, дүгнэлт, хавсралт материал бүхий 141 хуудас тайлбар бичиг, 13 хавсралт зургуудаас бүрдэж байна.

4. "Хөв" нэртэй барилгын чулууны ордын SGMV-00009 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын ХХ-12-04 тоот дүгнэлтэд үндэслэн гаргасан, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Н/114 дүгээр тушаалаар бодитой (В) зэрэглэлээр 442,770.0 м³ буюу 1,151,202.0 тн, боломжтой (С) зэрэглэлээр 145,000.5 м³ буюу 377,011.3 тн, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 587,770.5 м³ буюу 1,528,203.3 тн гэж ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төсөлд ил уурхайн хувьд ашиглалтын үеийн хаягдал 1.06% буюу 5.4 мян.м³, бохирдлыг 1.58% буюу 7.9 мян.м³ байхаар тооцож геологийн бодитой болон боломжтой (В+С) зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцооноор үйлдвэрлэлийн нийт 506.6 мян.м³ буюу 1,317.3 мян.тн барилгын чулуу олборлохоор байна. Үйлдвэрлэлийн энэхүү жилд 140 мян.м³ хүдэр олборлох хүчин чадалтайгаар 4 жилийн хугацаанд ажиллахаар төлөвлөжээ.

6. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын уул геологийн тогтоц, хучаас хөрсний зузаан, физик механик шинж чанар зэргийг харгалзан үзэж ил уурхайн хөрс хуулалтын ажлыг авто тээвэртэй, гадаад овоолготой ил уурхайн ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

7. Уурхайд Everdrim-ECD45 маркийн өрмийн машин 1 ширхэг, LuiGong-CLG933H маркийн экскаватор 1 ширхэг, 25 тн даацтай NorthBenz маркийн автосамосвал 2 ширхэг, LuiGong-CLG885H маркийн утгуурт ачигч 1 ширхэг зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөжээ.

8. Ордын барилгын чулууны физик-механикийн болон ширхгийн найрлагын шинжилгээ, бетоны найрлага тогтоох, хими, урвалжих чадвар, элэгдэлт, шахалтын бат бэхийн шинжилгээнүүдийг БАК-ийн лаборатори, Геологийн төв лаборатори, МУИС-ийн Цөмийн судалгааны төвд тус тус хийлгэсэн ба MNS-2803:2004, MNS-346:2000 стандартуудын шаардлагыг бүрэн хангасан байна. Уурхайгаас олборлосон 506.7 мян.м³ барилгын чулууг тээвэрлэн ангилан ялгах хэсэгт буулгаж 2 шатны бутлалт, 1 шатны шигшүүрээр ангилан, 5-10мм-ийн ширхэглэгтэй дайрга 1.0 мян.м³, 10-20мм-ийн ширхэглэгтэй дайрга 18.5 мян.м³, 20-40мм-ийн ширхэглэгтэй дайрга 417.2 мян.м³, +40мм-ийн ширхэглэгтэй дайрга 69.0 мян.м³, нийт 505.6 мян.м³ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр тооцжээ.

9. Хөвийн барилгын чулууны орд нь өмнөд бүсийн цахилгаан дамжуулах шугамаас 4 км зайд байрлах ба хамгийн ойр байрлах "Нарийн Сухайт Эрчим" ХХК-ийн дэд станцаас уурхайн талбай хүртэл 6 кВ-ын ЦДАШ-аар төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон бөгөөд нийт цахилгаан эрчим хүчний ачаалал 298.5 кВА, цахилгаан эрчим хүчний зарцуулалт 1,727.5 мян.кВт/жил байна. Төслийн нийт усны хэрэглээ 108.6 мян.м³ бөгөөд үүнд унд ахуйн хэрэглээнд 16.6 мян.м³, ил уурхайн хэрэглээнд 91.9 мян.м³ тус тус байна. Усан хангамжийг гүний худгаас хангахаар төлөвлөжээ.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 367.9 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс бэлтгэл ажлын зардалд 80.0 сая төгрөг, байгаль орчин хамгаалах зардалд 100.0 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн

зардалд 78.0 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 29.8 сая төгрөг, төслийн хаалт, мониторингийн зардалд 80.0 сая төгрөг зарцуулахаар төсөлд тусгажээ.

11. Уг төслийг хэрэгжүүлснээр 76 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 2.3 сая төгрөг байхаар байна.

12. "Хөв" нэртэй барилгын чулууны ордыг ашиглах төсөл хэрэгжүүлэхэд нэмэлтээр 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс цахилгаан хангамж 150.0 сая төгрөг, бутлуурын цех 695.0 сая төгрөг, усан хангамж 54.0 сая төгрөг, барилга байгууламж 725.0 сая төгрөг, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл 330.0 сая төгрөг, уурхайн туслах тоног төхөөрөмж 195.0 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд жилд дунджаар 555.0 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

13. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 21.7 тэрбум төгрөгийн зардал гарган, 25.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого хийж, 3.5 тэрбумын татварын өмнөх, татварын дараах байдлаар 3.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Төсөл хэрэгжих хугацаанд улс, орон нутгийн төсөвт 5.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд 1 м³ дайрганы бүрэн өөрийн өртөг 42.9 мян.төг байна.

14. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 2.03 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 1.12 тэрбум төгрөг, төслийн өгөөжийн дотоод норм (IRR) 34%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 2.05 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголын захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна. Үүнд:

1. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийх;
2. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/231, А/368 тоот тушаалаар батлагдсан Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж, хэрэгжилтийг ханган ажиллах;
3. Төсөл захиалагч нь шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах;
4. Төсөл захиалагч нь Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

5. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн Гоулдмэн Прожект ХХК, мөн төслийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Я.Доржсүрэн, Уул уурхайн мэргэшсэн инженер Г.Батзаяа нар хариуцах.

Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших SGMV-00009 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Хөв" нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авах;
2. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших SGMV-00009 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Хөв" нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол, түүнийг хуулсан диск, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА

Л.БАЯРМАНДАЛ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ ДАРГА

М.МЭНДБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ХУЛАН

Огноо/Date: 2023.08.23 12:13:38				
Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information				
Журналын/Journal No: 000522866706				
Системийн огноо/System Date: 2023.08.23 12:13:38				
Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number 5589168218	Нэр/Name ЧУХАМЖАРГАЛАН	Дүн/Amount 5,000,000.00 MNT	Ханш/Rate 1.00
/ Таван сая төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 90 IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 100900013406	Банкны нэр/Bank Name State Fund - Төрийн Сан Нэр/Name БО нөхөн сэргээх баталгаа	5,000,000.00 MNT	1.00
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-Чухамжаргалан ХХК 3614093				
Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers				
Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:				
Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:				
Гарын үсэг/Signature:				
Тамга/Stamp:				
_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)				



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Ардатын 624, 23 дугаар хороо,
Хэн-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: 25 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2023.11.30 № 12 / 6250
танай _____-ны № _____-т

ЧУХАМ ЖАРГАЛАН ХХК-Д

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай байгууллагаас ирүүлсэн Өмнеговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших SGMV-00009 тусгай зөвшөөрөлтэй "Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах" төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2024 оны 2 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлнэ үү.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт 3 хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ц.УРАНЧИМЭГ

• 152396122

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

**ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС**

2023 оны 11-р сарын 27

Улаанбаатар хот

Дугаар 2022/ОА-195

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "ЧУХАМ ЖАРГАЛАН" ХХК, Өмнөговь, Даланзадгад, Далан баг, Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс 2 давхар.

Холбоо барих утас, И-мэйл хаяг: +976 99074919 9929211




Төслийн нэр: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших SGMV-00009 тусгай зөвшөөрөлтэй "Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах" төсөл.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Өмнөговь аймгийн Гурвантэс сум.

Санал: Сумын Засаг даргын 2023 оны 11 сарын 21-ны өдрийн 01/651 дугаар албан бичиг, АМГГГ-ын даргын 2023.09.20-ны өдрийн Т/97 дугаар тушаал, И-Монгол цахим системийн 077-2311-000107 тоот хүсэлтийг тус тус үндэслэв.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм			
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хиллийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	Хууриар хоргилсон хязгаарласан газар байгаа эсэхийг нарийвчилсан үнэлгээний шатанд тодорхойлох
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмсэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				Тийм
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	

	Гадаргын болон газрын доорх усанд бохирдог үүсэх, эсэх			Тийм	
Хөрсөн бүрхэвч					
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
Ургамлан нөмрөг					
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
Амьтны аймаг					
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм	
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
		Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх			Тийм
		Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм
		Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм
		Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм
	Түүх, соёлын биет өв				
		Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
		Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм
		Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм
Нэгдсэн дүгнэлт:					
Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших SGMV-00009 тусгай зөвшөөрөлтэй "Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах" төсөлд батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.					
Онцгойлон анхаарах зүйлс:					
1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хийлгэх бөгөөд олборлолтын технологийн дарааллыг нарийвчлан тодорхойлж, технологийн сонголтод үнэлэлт дүгнэлт өгөх;					
2. Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчин /агаар, ус, хөрс, амьтан, ургамал г.м/-д үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг тооцож, нийлбэр үнэлгээг гарган уг төслийн экологи, эдийн засгийн үр ашигтайгаар хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;					
3. Тухайн орд газрын гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарал, уст үеийн хөдөлгөөн, тархалтыг олборлох технологитой уялдуулан нарийвчлан судалж, эрх бүхий байгууллагаар усны нөөцийн дүгнэлт гаргуулах;					
4. Төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлыг хэмжээ, түүний тархалт, нөлөөллийг хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;					

<p>5. Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг нарийвчлан тооцож, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тухай бүс нутагт орших эвдрэлд орж, эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх замаар биологийн олон янз байдлын амьдрах орчныг сэргээхээр саналыг боловсруулж, шаардагдах зардлыг тайланд тусгах;</p> <p>6. УУХҮ-ийн болон БОАЖ-ын сайд нарын 2019 оны 8-р сарын 28-ны өдрийн А/181, А/458 дугаар тушаалаар батлагдсан "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын дагуу Ордын ашиглалт дууссаны дараах хаалтын нөхөн сэргээлт, мониторинг хийх төслийг боловсруулж, хаалтын ажлын каледарчилсан төлөвлөгөө, зардлын тооцоог урьдчилан тооцож, тайланд тусгах;</p> <p>7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг эхний 5 жилээр тооцож ирүүлэх;</p> <p>8. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах;</p> <p>9. Уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн талаар болон эцэслэн боловсруулсан БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих баг/хорооны ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсарган саналыг тусгах;</p> <p>10. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхцалтай эсэх лавлагаа БОАЖЯ-наас авч тайланд хавсаргах.</p> <p>11. Батлагдсан техник, эдийн засгийн үндэслэлийн тушаал, дүгнэлтийг тайланд хавсаргах.</p> <p>12. Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтаар авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангаж байгаа талаар тусгайлан дүгнэлт гаргаж, нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах.</p> <p>13. Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн хүчин чадалд тулгуурлан мод тарих, модны төрөл зүйл, тоо хэмжээг тайланд тусгах;</p>	
<p>Бусад зүйлс:</p> <p>1. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг тухай бүрт ханган биелүүлэх;</p> <p>2. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаан хэрэгжүүлэх;</p> <p>3. Төслийн хүчин чадал, техник, технологит өөрчлөлт орсон тохиолд ерөнхий үнэлгээнд тухай бүрт хамрагдаж шийдвэр гаргуулж ажиллах шаардлагатай болно.</p> <p>Дээрх дурьдсан арга хэмжээг цаг хугацаанд ханган биелүүлээгүй тохиолдолд Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож, "Зөрчлийн тухай" хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцдог болохыг анхаарна уу.</p>	
<p>Ерөнхий үнэлгээ хийсэн: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖЭЭЧ Гарын үсэг:</p>  <p>О.АМАРСАНАА</p>	<p>Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн: "ЧУХАМ ЖАРГАЛАН" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Гарын үсэг:</p>  <p>А.ТЭМҮҮЛИН</p> 

--- оОо ---